

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН 2021

Улаанбаатар хот
2022



ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН 2021

Бэлтгэсэн:

Б. Пүрэвсүрэн
Г. Болдмаа
Ц. Лхагвасүрэн

Хянасан:

Л. Галбаатар

Тус тайланг Чөлөөт илэрхийллийн олон улсын сүлжээ /IFEX/ болон Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр бэлтгэв.

ГАРЧИГ

Товчилсон үгсийн жагсаалт.....	4
ӨМНӨТГӨЛ.....	5
НЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ	7
1.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа	8
1.2. Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа	10
1.3. Сэтгүүлчийн нууц эх сурвалж.....	13
1.4. Мэдээллийн эрх чөлөө ба хязгаарлалт	14
1.5. Сонгууль ба хэвлэл мэдээлэл.....	16
1.6. Нэр төр гутаахтай холбоотой зохицуулалт	18
1.7. Агуулгын хязгаарлалт.....	20
1.8. Бусад зохицуулалт	24
ХОЁР. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ	30
ГУРАВ. СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭСРЭГ ИРГЭНИЙ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ.....	35
Хавсралт 1. Ковид-19 цар тахлын үе дэх иргэний болон улс төрийн эрхийн зөрчлийн мониторинг (2020.11.20-2022.03.31).....	38
Хавсралт 2. Ковид 19 буюу коронавируст цар тахлын үе дэх сэтгүүлчдийн аюулгүй байдлын судалгааны дүн	73
Хавсралт 3. Монгол Улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүрэн дүүрэн баталгаажуулахад дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаарх санал.....	86

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ГИТ	Глоб Интернэшнл Төв
УИХ	Улсын Их Хурал
НМИТБтХ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
МИТБМАЭ	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
ХХМХтХ	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЭХЭЗБ	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ИБУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз

ӨМНӨТГӨЛ

Жил бүрийн 5 сарын 3-ны өдөр дэлхий даяар тэмдэглэдэг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр” (ДХЭЧ)-т зориулан Монгол дахь Хэвлэлийн эрх чөлөөний ээлжит тайлангаа та бүхэнд толилуулж байна.

31 дахь жилдээ дэлхий нийтээрээ тэмдэглэж буй 2021 оны ДХЭЧ-ний өдрийг энэ жил “Цахим дайралтад өртсөн сэтгүүл зүй ” сэдвийн дор тэмдэглэж байна. ЮНЕСКО-гийн үзэл баримтлалд дурдсанаар “Сүүлийн үед төрийн болон төрийн бус байгууллагуудын хөгжүүлээд буй дэвшилтэт тандалтын технологи, нээлттэй мэдээлэл/өгөгдөл цуглуулалт болон хиймэл оюун ухаан нь сэтгүүл зүй, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө төдийгүй хувь хүний нууцлалд олон арга замаар нөлөөлж буйг онцлохын тулд” энэ сэдэвт анхаарал хандуулж байна.

ЮНЕСКО-гийн үзэл баримтлалын хүрээнд дэлхийн хэмжээнд болон дотооддоо нийтээрээ хэлэлцвэл зохих гурван дэд сэдвийг “Цахим дайралт”, “Ил тод байдал олон нийтийн сайхан сайхны төлөө”, “Хэвлэл мэдээллийн оршин тогтохуй ба олон нийтийн итгэл” хэмээн тодорхойлжээ.

ЮНЕСКО 2022 оны тавдугаар сарын 2-5-ны өдрүүдэд Уругвай Улсын Засгийн газартай хамтран, Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр (ДХЭЧӨ)-т зориулсан Дэлхийн чуулган зохион байгуулж, хэвлэлийн эрх чөлөөг дэмжигчдийг дэлхийн өнцөг булан бүрээс оролцох боломжийг олгох юм. Дэлхийн чуулган цахим эрин үе нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдал, хэвлэл мэдээллийн оршин тогтнохуй төдийгүй олон нийтийн итгэлд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох зорилготой. “Сэтгүүл зүйн практикт тулгарч буй сорилтууд улам бүр нэмэгдсээр байгаа энэ цаг мөчид Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний нийгэмлэг, хөдөлгөөнийхөн эргэн нэгдэх цаг болжээ” хэмээн ЮНЕСКО-гийн үзэл баримтлалд дурджээ.

Өнгөрсөн жил хоёр сэтгүүлч, Филиппиний Мария Ресса, ОХУ-ын Дмитрий Муратов нар Нобелийн энх тайвны шагнал хүртсэн нь онцгой үйл явдал байлаа. ЮНЕСКО-гийн Дэлхийн чиг хандлагын тайлангийн хамгийн сүүлийн үеийн «Чимээгүй заналхийлэл: Сэтгүүлчдийн аюулгүй байдлын чиг хандлага» сэдэвт хэлэлцүүлгээс гаргасан судалгаанд тандалт болон хакердах ажиллагаа сэтгүүл зүйг хэрхэн сүйтгэж байгааг онцолж байна. Энэ нь эрэн сурвалжлах сэтгүүлч, судлаачдын илтгэлүүдэд тод харагдаж байгаа төдийгүй НҮБ-ын хүний эрхийн экспертүүд тандалтын технологийг худалдах, шилжүүлэхийг дэлхийн хэмжээнд түр зогсоохыг уриалахад нөлөөлөв.

2022 оны байдлаар дэлхийн 135 орон мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан бие даасан хуультай байна. Манай улсад үйлчилж байсан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль 2022 оны тавдугаар сарын нэгнээс хүчингүй болж, оронд нь 2021 оны 12-р сарын 17-ны өдөр УИХ-аас баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль үйлчилж эхэлнэ. УИХ

мөн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг мөн өдөр баталсан юм. Манайд олон жил яригдсан өгөгдөл хамгаалах асуудал эдгээр хуульд туссан нь эерэг хандлага боловч Төрийн ба албаны нууцын тухай хуульд нэмэлт өөрчлөлт хийгээгүй нь үр дүнтэй хэрэгжилтэд эргэлзээ төрүүлж байна.


Манай байгууллагаас хот, хөдөөгийн 233 сэтгүүлчийг хамруулан хийсэн сэтгүүлчдийн аюулгүй байдлын судалгаанаас харахад, тэдний 57 хувь нь мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалздаг нь сэтгүүлч хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудад тулгардаг нэн тэргүүний бэрхшээл гэжээ. Судалгаанд хамрагдагчдын 20 хувь нь шүүх, цагдаа, прокурорт дуудагдах нь хоёр дахь бэрхшээл гэсэн байна. Сэтгүүлчид мөн тэднийг имэйл, цаашилбал биечлэн заналхийлэх, мэдээлэл хулгайлах, хувийн онлайн орон зайд халдаж мөрдлөг хийх, хакердах гэсэн асуудлуудыг нэрлэсэн нь анхаарал татаж байна.

2022 онд “Хил хязгааргүй сурвалжлагчид” (RSF) олон улсын байгууллагын Хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс өнгөрсөн жилийн үзүүлэлтээс 22 байр ухарч, дэлхийн 180 орноос 90 дугаар байранд жагсаж, хэвлэлийн эрх чөлөөний “мэдэгдэхүйц асуудал”-тай орны тоонд багтсан хэвээр байна.

Х.НАРАНЖАРГАЛ

Глоб Интернэшнл төвийн

Удирдах зөвлөлийн дарга



НЭГ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ



1.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” бүлгийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхээр заасан. 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, мөн 16 дугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан. Мэдээлэл “түгээх” эрхийн тухай үгчлэн оруулаагүй хэдий ч өмнө дурдсан олон улсын гэрээ, конвенцын дагуу “хил хязгаар үл харгалзан”¹ мэдээлэл “хайх, хүлээн авах болон түгээх” эрх баталгаажсан гэж үздэг.

Монгол Улс НҮБ-д 1961 онд гишүүнээр элсэн орсны 60 жилийн ой 2021 онд тохиов. Гишүүн орны хувьд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ыг хүлээн зөвшөөрнө. Түүнчлэн 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг соёрхон баталж, 2012 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэн. Тиймээс олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу иргэдийнхээ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй. Энэ үүргийг Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Эдгээр олон улсын гэрээ 2004 оны “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаарт монгол хэлнээ албан ёсоор хэвлэгдсэн.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана”. ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой; а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” гэж хязгаарлалтыг нарийвчлан тодорхойлжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарим хязгаарлалтыг Үндсэн хуулийн үзэл баримтлал болоод олон улсын гэрээ конвенцыг удирдлага болгож, гурван талт шалгуур /Three part test/-ыг бүрэн хангасан үед л хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнд:

¹ ИБУТЭОУП-ын -19р зүйл (2)



Нэгдүгээрт. Гагцхүү хуулиар тогтоох буюу хууль ёсны зорилготой байх

Хоёрдугаарт. Хэм хэмжээндээ байх буюу олон улсын хуулиар хүлээн зөвшөөрсөн хязгаарлалтын зарчимд нийцэх

Гуравдугаарт. Зайлшгүй буюу гарцаагүй байх.

Үүнээс илүү хязгаарлалт хийхийг ардчилсан нийгэмд хүлээн зөвшөөрөх ёсгүй хэдий ч хэтийдсэн хязгаарлалтыг хууль тогтоомжид тусгах, эсвэл практикт хэрэглэсээр байна. 2011 оны 7 дугаар сарын 11-29-ний өдрүүдэд Женев хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 102 дугаар чуулганаар баталсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн талаарх 34 тоот Ерөнхий тайлбарыг² монгол хэлнээ албан ёсоор орчуулж, практикт хэрэглэж хэвших, олон нийтэд болон холбогдох албан тушаалтнуудад таниулан сурталчлах шаардлагатай байна.

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орж, зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж зааснаар тодорхой асуудлаар иргэдийн мэдээлэл эрж хайх, хүлээн авах, түгээх эрхийг баталгаажуулсан юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” хэмээн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавьж болох зорилго, үндэслэлийг заасан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэж заасан байдаг. Итгэл үнэмшилтэй байвч түүнийгээ илэрхийлэх арга хэрэгсэлгүй бол энэ эрх хэрэгжих боломжгүй юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 14.3 дугаар зүйлд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдахыг гэмт хэрэгт тооцож байна. Тодруулбал, “Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол...” гээд хүлээх хариуцлагад торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заасан. Тэгвэл Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойших хугацаанд уг гэмт хэргийн дагуу 2018-2022 оны дөрөвдүгээр сарын нэгний өдрийн байдлаар нийт 11 гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад ирснээс яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлж шийдвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй тухай Цагдаагийн ерөнхий

² https://www.gic.mn/public/docs/publications/General_comment_No34_ICCPR_Art19_mon.pdf

газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас ГИТ-д ирүүлсэн³ албан бичигтээ дурдсан. Үүнээс дүгнэвэл, иргэний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг Эрүүгийн хуулиар хамгаалж, гэмт хэрэгт тооцох болсон боловч иргэд төдийгүй сэтгүүлчид хүртэл цагдаагийн байгууллагад эдгээр эрх зөрчигдсөн асуудлаар тэр бүр гомдол гаргаж, асуудлаа шийдвэрлүүлэх нь ховор байна.

1.2. Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа

1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2, 3, 4 дүгээр зүйлд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргах болон төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг тус тус хориглосон нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан суурь зохицуулалт болдог.

Улсын Дээд Шүүхийн тайлбарт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэдгийг “Зар сурталчилгааны тухай” хуулийн 3.1.5 дахь хэсэгт заасан “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерын сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно хэмээн тогтоосон. УИХ-аас 2005 оны нэгдүгээр сарын 27-ны өдөр “Олон нийтийн радио, телевизийн тухай” хууль баталснаар үндэсний хэмжээнд олон нийтэд үйлчлэх, түүний хяналт, санхүүжилт бүхий статустай телевиз, радиогийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Түүнээс хойш хэвлэл мэдээллийн салбарт шаардлагатай байгаа сэтгүүлчийн нууц эх сурвалж болон мэдээлэгчийг хамгаалах, салбар дахь шударга өрсөлдөөн, өмчлөлийн ил тод байдлыг хангах тухай эрх зүйн зохицуулалт хийгдээгүй. Харин УИХ-аас 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг батлав. Эрх баригч Монгол Ардын Нам 2020 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийнхөө 4.4.2-т “Хэвлэлийн эрх чөлөөг хуулиар хамгаалж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг хязгаарласан аливаа бодлого хэрэгжүүлэхгүй” тухай заажээ. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэд хэдэн төсөл боловсруулагдаж байсан ч, УИХ-аар хэлэлцүүлж батлуулаагүй хэвээр байна.

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр “МОНЦАМЭ” агентлагийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяанд шилжүүлсэн Монгол Улсын Засгийн газрын 400 дугаар тогтоол⁴ гарсан. Энэхүү үйлдэл нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дэх хэсэгт заасан “төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй юм. МОНЦАМЭ агентлаг нь улсын төсвөөс санхүүждэг төдийгүй Засгийн газар болон бусад аливаа төрийн институцид албан ёсоор харьяалагдах нь Хэвлэл мэдээллийн

³ -2022.04.13ны өдрийн 86/761 тоот албан бичигт

⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389864121051>

эрх чөлөөний тухай хуулийн зөрчил юм. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдсантай холбоотойгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын 1998 оны 103 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт “Радио, телевизийн хэрэг эрхлэх газар, МОНЦАМЭ агентлагийг Засгийн газрын тохируулагч агентлагийн хувьд татан буулгаж, Үндэсний нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болгон өөрчлөн зохион байгуулсугай.” гэсэн шийдвэргарснаар өнөө хүртэл эрх зүйн статус нь тодорхойгүй хэвээр байгаа юм. Хожим буюу 2015 онд УИХ-ын 58 дугаар тогтоолоор дээрх 1998 оны 103 дугаар тогтоолын зөвхөн 2 дахь заалт буюу “Хууль, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар болон хуулиар олгогдсон эрх бүхий байгууллагын нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг гагцхүү Төрийн мэдээлэл эмхэтгэлд албан ёсоор хэвлэн нийтэлж байхаар тогтоосугай.” гэснийг хүчингүй болгосноос үзвэл, УИХ-ын 1998 оны дээрх 103 дугаар тогтоолын 4 дэх заалт одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилсээр байтал Ерөнхийлөгчийн Тамгын газар нь дэргэдээ МОНЦАМЭ агентлагийг харьяалуулах шийдвэр гаргасан нь холбогдох хууль болон тогтоолыг зөрчсөн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, 2022 оны 3 дугаар сард олон нийтэд танилцуулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд “Доромжлох” гэмт хэргийг Эрүүгийн хуульд дахин нэмж оруулахаар болсон. Тодруулбал, Эрүүгийн хуульд нэмэх 13.15 дугаар зүйлд 13.15.1-д “Хүний нэр төр, алдар хүндийг олон нийтэд гутаан доромжилсон бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж заасан. Энэ нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг цагдаагийн байгууллагаас дуудах, мэдүүлэг авах, мөрдөн шалгах, улмаар сэтгүүлчид өөрийн цензурт автах эрсдэлийг бий болгох юм.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 7.1.2 дахь хэсэгт “хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах” эрхтэй байхаар хуульчилсан. Энэ дагуу 2021 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын А/01 тоот тушаалаар ⁵Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, санал боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд санал боловсруулж ХЭҮК-т хүргүүлээд байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр УИХ-аас дараах хэд хэдэн бодлогын баримт бичгийг боловсруулан баталсан. Тухайлбал, УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.5-д “Мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах талаар” авах арга хэмжээг тусгасан бөгөөд

⁵ <https://nhrcm.gov.mn/%D%0BC%D8%1D%D%0B%4D8%1D%D8%1D/freedom/>

тус хөтөлбөрийн 2.2.5.4-т “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох бүх хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно”; 2.2.5.6-д “Мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулж, иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний нэр, нэр төр, алдар хүндийн халдашгүй байх эрхийг зөрчихөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь бүрэн сэргээх эрх зүйн механизмыг тодотгон сайжруулна” гэж тус тус заасан⁶.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.5.9-д “Хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ”⁷ гэж заасан бол Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.4-т “Хэвлэл мэдээллийн салбарыг үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх чиглэлээр хөгжүүлнэ”⁸ гэсэн байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ” (3.3.3.2); “хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана” (3.3.4.3) гэж заасан байдаг.

Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг хэвлэлийн эрх чөлөөний 2022 оны индексээр Монгол Улс 180 орноос 90 дугаар байрт⁹ жагсаж байна. Энэ нь өмнөх оныхоос 22 байр ухарсан үзүүлэлт бөгөөд хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал “асуудалтай” орны тоонд багтсан хэвээр байна. Хил хязгааргүй сурвалжлагчид байгууллагаас уг судалгааг 2002 оноос хойш дэлхийн 180 улсыг хамруулан хийж байгаа бөгөөд манай улс 2013 оноос хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдлаа үнэлүүлж эхэлсэн. Тухайлбал, 2013 онд 98-д, 2014 онд 88-д, 2015 онд 54-д, 2016 онд 60-д, 2017 онд 69-д, 2018 онд 71-д, 2019 онд 70-д, 2020 онд 73-д, 2021 онд 68, 2022 онд 90 дугаар байруудад тус тус жагсаж байсан. Хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал “хангалттай сайн” гэдэг ангилалд багтахын тулд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг өргөн хүрээнд бодитой хамгаалах зайлшгүй шаардлагатай.


⁶ УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”

⁷ УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2030-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”

⁸ ЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2024-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”

⁹ <https://rsf.org/en/ranking>

Хэвлэлийн эрх чөлөөний индекс Монгол улс



1.3. Сэтгүүлчийн нууц эх сурвалж

Монгол Улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалахтай холбоотой хууль байхгүй. Зөвхөн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хороодын 2015 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан ёс зүйн зарчмын 8 дахь хэсэгт “Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална” гэж зааснаар сэтгүүлчид нууц эх сурвалжаа хамгаалах ёс зүйн үүрэг хүлээлгэдэг.

Үүнээс гадна, 2016 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тоот тогтоолоор баталсан бөгөөд түүний 4.1.8 дахь хэсэгт хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдал, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлууд хийхээр тусгаад байна. Тухайлбал:

- хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл олж авах, түгээх эрхийг баталгаажуулах /4.1.8.1./;
- эрэн сурвалжлах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлчийг аливаа дарамт, шахалтаас хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагааных нь улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг өөрчилж, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох /4.1.8.2./;
- хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх /4.1.8.3./ гэж тус тус заасан.

Эдгээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө батлагдаж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор сэтгүүлчийн нууц эх сурвалж, шүгэлдэгчийг хамгаалсан эрх зүйн орчныг бүрдүүлэхээр Засгийн газрын

хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг 2021.11.11-ний өдөр УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн барьсан. УИХ-ын хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 2022.01.18-ны өдрийн УИХ-ын 08 дугаар тогтоолоор баталсан¹⁰ бөгөөд Иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл багтсан байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг УИХ-аас 2021 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан бөгөөд уг хууль 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Гэвч хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хүний эрх хамгаалагчийн хороо байгуулагдаагүй, Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн ХЭҮК-ийн гишүүн одоо хүртэл сонгогдоогүй байна.

1.4. Мэдээллийн эрх чөлөө ба хязгаарлалт

2022 оны байдлаар дэлхийн 135 орон мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан бие даасан хуультай байна.

УИХ-аас 2021.12.17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиудыг баталсан. Дээрх хуулиуд 2022.05.01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор МИТБМАЭ-ийн тухай хууль хүчингүй болж байна. “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн тухай хуульд нийтийн мэдээллийг “нээлттэй”, “хязгаарлалттай”, “хаалттай” гэж ангилсан бөгөөд түүний 7.2-т “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ”, 7.3-т “Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ” гэж, 7.4-т “Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг хаалттай мэдээлэл гэж үзнэ” гэж тус тус заасан. Мөн хуулийн 8 дугаар зүйлд мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээний нийт 67 нээлттэй мэдээллийн жагсаалтыг тусгасан. Гэвч төрийн мэдээлэл дээд зэргээр ил тод байх, нууцалбал зохих мэдээллийг зөвхөн нийтийн эрх ашгийн шалгуурт үндэслэн хуулиар тогтоосны үндсэн дээр нууцлах зарчимтай тус хууль нийцэхгүй байна. Тодруулбал, хуулийн 3.1-т “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгоход энэ хууль үйлчлэхгүй”, 7.6-д “Хаалттай, хязгаарлалттай мэдээлэлд хамаарах төрийн болон албаны нууцтай холбогдох Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэх заалтууд нь Төрийн болон албаны нууцын хуулийг огт хөндөөгүй, улмаар “төрийн нууц”, “албаны нууц” нэрийн дор олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлыг үл хайхран мэдээллийг нууцлах, мэдээлэл өгөхгүй байх, төрийн байгууллага, албан тушаалтны алдаа, дутагдлыг

¹⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16390150786561>

нуух, хаацайлах өнөөгийн байдлыг залруулахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль үр дүнгүй байх шинжтэй байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтнууд ашиг сонирхлын мэдүүлгээ, Авлигын эсрэг хуулиар өөрийн болон гэр бүлийнхээ хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлэх үүрэг хүлээсэн тул энэ төрлийн мэдээлэл нээлттэй болж байна. 2018 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийг тус тус баталсан.

Дэлхий нийтэд дэгдсэн ковид-19 цар тахлын улмаас мэдээллийн урсгалыг хязгаарласан хууль тогтоомжууд батлагдан хэрэгжив. Тухайлбал, УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан¹¹ Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд хэд хэдэн заалт орсон байна. Үүнд:

- 9.13. Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 12.3. Цар тахал түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл түгээхийг хориглоно.
- 13.3. Цар тахал түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл түгээхийг хориглоно тус тус заажээ.

Цар тахлын дээрх түр хууль батлагдсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 10.4.13 дахь хэсэгт “олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх.”, Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.

Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил 2020

¹¹ Энэхүү хуулийн үйлчлэлийг 2021.12.30-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулж, хугацааг 2022.12.31-ний өдрийг дуустал үргэлжлэхээр зохицуулсан.

онд 1790 гарснаас хялбаршуулсан журмаар 667 зөрчлийг шалган шийдвэрлэж, 1123 хэрэг нээн шалгаж, 1480 хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан тухай УЕПГ-ын 2021.06.18-ны өдрийн 4/3650 албан бичигт дурдсан байна. Үүнээс 190 зөрчлийн хэргийг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хянан шийдвэрлэжээ. Тус 190 зөрчлийн хэргийн хэдэн хувийг хэрэгсэхгүй болгож эсхүл хүчинтэй хэвээр үлдээсэн эсэх талаар нарийвчилсан тоон мэдээлэл эрх бүхий байгууллагын мэдээллийн санд бүртгэгдээгүй байна.

1.5. Сонгууль ба хэвлэл мэдээлэл

УИХ-аас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан. Тус хуулийн 26.6-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж заасан. Энэ зохицуулалт сонгуулийн бусад хуульд нэгэн адил тусгагдсан. Тухайлбал, МУИХС-ийн тухай хуулийн 29.8-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно” гэж заасан. Тус хууль болон Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн “Сонгууль эрхэлсэн байгууллага, сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа” гэсэн бүлгүүд нь бүхэлдээ нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, түүний агуулгын хяналт, хэвлэмэл болон радио телевиз, цахим орчноор мэдээлэл түгээхтэй холбогдсон зохицуулалтыг оруулсан. Мөн “Сонгуулийн сурталчилгаа” бүлэгт өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх заалт багтсан. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглахыг өмнөх сонгуулийн тухай хуульд тусгагдсанаас илүү дэлгэрүүлэн авч үзэв. Ингэхдээ цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтэлнэ.

Цаашилбал, МУИХС-ийн хуулийн 48.7 дахь хэсэгт “Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно” гэж зааснааранхудаагаа “хаалтын гэрээ”-г хориглосон зохицуулалт орсон юм. Бүх шатны сонгуулийн тухай хуулиудаар (Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулиуд) нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа хэсэгт “Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглоно” гэсэн зохицуулалт шинээр орсон.

Сонгуулийн тухай дээрх хуулиуд батлагдсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар бүлэгт “Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил”-ийн бүлгийг 2019.12.20-ны өдрийн хуулиар шинээр нэмсэн. Энэ дагуу сонгуулийн тухай хууль

тогтоомжийг зөрчсөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 20 саяас 200 сая хүртэлх торгуулийн шийтгэлийг Зөрчлийн тухай хуулиар оногдуулахаар хуульчилсан нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад эдийн засгийн цензур тогтоох эрсдэлтэй байгаа юм.

Нөгөө талаас, сонгуулийн жил бүрийн өмнө эрх зүйн орчныг шинэчлэн найруулдаг уламжлал тогтсон. Ингэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хараат бус, бие даасан мэдээ, нийтлэл түгээхийг хуулиар улам бүр хязгаарлаж, сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нь хатуу хязгаарлалт тогтоож буй нь эрх зүйн цензурийг нэгэнт бий болгожээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-т “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” гэж заасан. Нөгөө талаас, МУИХС-ийн тухай хуулийн 46.19, түүнтэй уялдсан Зөрчлийн тухай хуульд хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан хариуцлага хүлээлгэдэг байхаар тусгасан нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна. Сонгуулийн үеийн хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо¹² хүчингүй болгохоор байгаа нь буруу юм. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Харилцаа холбооны зохицуулах хорооноос хяналт тавих, төрийн аливаа хэлбэрийн цензурийн хэлбэр амь бөхтэй оршсоор байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн тухай хуулиуд батлагдсантай холбоотойгоор хэд хэдэн журмыг боловсруулан баталсан. Тухайлбал, “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”, “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам” зэргийг батлан гаргаж ХЗДХЯ-нд хэм хэмжээний актаар бүртгүүлээд байна. Энэхүү журмууд нь 2021 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хэрэгжсэн.

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг баталсан. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2019 оны 5 дугаар сард Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд сонгуулийн санал хураалт эхлэхийн өмнө сурталчилгаа дуусахаас өмнө гарсан гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зохицуулалт хийж байгаа талаар танилцуулсан.¹³ Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.8-д “Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно” гэж заасан бөгөөд 2019 онд нэмсэн 10 дугаар зүйлд “Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ” хэмээн тусгаснаар¹⁴ өнгөрсөн 2021 оны

¹² Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар тоот тогтоолоор Цахим хөгжил, харилцаа холбооны яам болгон өөрчлөн байгуулсан.

¹³ “Хэвлэлийн мэдээллийн зөвлөл: Ёс зүйн зарчимд шинэ заалт нэмэгдлээ”. 2019.05.02 <https://news.zindaa.mn/2ps3>

¹⁴ Хэвлэл мэдээллийн зөвлөл. Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг. Улаанбаатар, 2020 он. 18 дахь тал

сонгуулийн үеэр энэхүү заалтыг дагаж мөрдсөн юм.

Энэ нь сонгуулийн жилд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага “худал мэдээлэл тараах”, “сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах” зөрчил гаргасан эсэх асуудлыг Хэвлэл мэдээллийн зөвлөл бие даан шийдвэрлэх тохиромжтой механизм болохыг харуулж байна.

1.6. Нэр төр гутаахтай холбоотой зохицуулалт

Хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг Үндсэн хуулиар хамгаалдаг. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-д “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй.... нэр төрийг нь доромжилж болохгүй....”, 17 дугаар зүйлийн 2-д “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” үүрэгтэй байхаар заасан.

Монгол Улсад иргэний нэр төр, алдар хүндийг Иргэний хууль болон Эрүүгийн хуулиар тусгайлан хамгаалж байна.

А. Эрүүгийн хуулийн зохицуулалт

2017 оны долдугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “Гүтгэх”, “Доромжлох” гэсэн хоёр зүйлийг хассан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахад гарсан ахиц болсон. Гэвч УИХ-аас баталсан 2020 оны нэгдүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр худал мэдээлэл тараахыг анх удаагаа гэмт хэрэгт тооцон хуульчилсан.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж заасан. Тэгвэл “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг өөрчлөн найруулахаар УИХ-ын нэр бүхий гурван гишүүнээс Эрүүгийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021.03.16-ны өдөр УИХ-д өргөн барьсан боловч батлагдаагүй.

2021 оны нэгдүгээр сарын нэгнээс 2022 оны дөрөвдүгээр сарын нэгний хооронд Эрүүгийн хуулийн Худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой 583 гомдол, мэдээлэл Цагдаагийн байгууллагад ирснээс татгалзах саналтай прокурорт шилжүүлсэн 472, хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн 95, ажиллагаанд шалгагдаж буй 14, Зөрчлийн тухай хуулийн 15.9 дүгээр зүйл Хуурамч дуудлага, мэдээлэл өгсөн үндэслэлээр торгосон 2 хэрэг мэдээллийн санд бүртгэгдсэн тухай 2022.04.13-ны өдрийн 86/761 тоот албан бичигтээ дурдсан байна.

Мөн Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд зааснаар сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараасан бол 450-5400 төгрөгтэй тэнцэх хэмжээний нэгжээр торгох, эсхүл 240-720 цаг нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэлтэй. Тэгвэл дээрх гэмт хэргийн дагуу Тагнуулын байгууллагад 2020 онд 135 гомдол ирснээс хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн 6, нээхээс татгалзсан 120, харьяаллын дагуу шилжүүлсэн 9 хэрэг. 2021 онд нийт 4 гомдол ирснээс бүгдэд нь хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн тухай Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газраас 2022.04.11-ний өдөр ирүүлсэн 16/342 тоот албан бичигтээ тус тус дурдсан байна.

Б. Иргэний хуулийн зохицуулалт

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд зааснаар “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй”. Мөн хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ”. Нэр төр сэргээлгэх тухай Иргэний хуулийн зохицуулалтын нэг асуудалтай тал нь нийтийн албанд хамаарах байгууллагад нэр төр сэргээх боломж олгодогт байна. Өөр нэг тулгамдсан асуудал нь Иргэний хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан бол түүнийхээ “бодитой”, “үнэн зөв” гэдгийг нотлохыг мэдээ тараагчид ногдуулсан.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаахгүй байхтай холбоотой зохицуулалт Сонгуулийн тухай хуулиудаар хязгаарлагдахгүй бөгөөд шинээр Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1.3-т “Хүний эрх хамгаалагч нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах”-ыг хориглоно гэж заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1998 оны A/RES/53/144 тогтоолоор “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тухай тунхаглал” (Хүний эрхийг хамгаалагчийн тухай тунхаглал)-ыг баталсан. Энэхүү тунхаглалд хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагаанд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдахыг хориглох зохицуулалт байхгүй.

Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд хүний эрхийг хамгаалагчийн нэр төрийг гутаах үйлдэл ихээр гарч байгаа талаар дурдсан болохоос хүний эрх хамгаалагчид нь бусдын нэр төрд халдахгүй байх зарчим, үүрэгтэй байхаар хориглосон шийтгэлийн төрлийг нэрлэн заагаагүй.

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон холбогдох олон улсын гэрээ, конвенцын дагуу бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдахгүй байх нь иргэний үндсэн үүрэг. Иймд Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд рүү халдах үйлдлийг хориглохоор тусгайлан заах онцын шаардлагагүй гэж үзэж байна. Энэхүү заалт нь эргээд Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд хориг саад бий болгох, цензур тогтоох, урвуулан ашиглах эрсдэлтэй гэж үзэж байна. Энэхүү хуулийн зорилтод “хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах” гэж заасан. Гэвч ХЭХЭЗБ-ын тухай хуулийн 8.1.3 дахь заалтад “Хүний эрх хамгаалагч нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах”-ыг хориглоно гэж заах нь тус хуулийн зорилтод нийцэхгүй, хүрэх зорилго, үр дүнг хумин боогдуулсан тул хариуцлага оногдуулах хэлбэрээр айлган сүрдүүлэх эрсдэл бий болгож байна. Тодруулбал, тус хуультай уялдуулан Зөрчлийн тухай хуульд нэмсэн 5.20 дугаар зүйлийн дагуу хүний эрх хамгаалагч нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

В. Зөрчлийн хуулиар

Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 5.13.2 дахь хэсэг “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж зохицуулсан. Тус заалтын дагуу 2021 онд шийдвэрлэгдсэн 1962 хэргээс зөрчлийн арга хэмжээ авагдсан 2424 тохиолдлын 2332 нь иргэн, үлдсэн 92 нь хуулийн этгээд байна. Нийт торгуулсан 2004 хүн, албадлагын арга хэмжээ авахуулж баривчлагдсан 329 иргэн байгаагаас есөд нь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хүчингүй болгож шийдвэрлэжээ. Зөрчлийн тухай хуулийн 5.13.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр нийт 1,706,265,000 /нэг тэрбум долоон зуун зургаан сая хоёр зуун жаран таван мянган/ төгрөгийн торгуулийн мөнгөн оногдуулсан талаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ГИТ-д ирүүлсэн 2022.04.18-ны өдрийн 03/447 тоот албан бичигтээ дурдсан байна.

1.7. Агуулгын хязгаарлалт

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Хүүхдийн эрхийн тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Архидан



согтуурахтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Зохиогчийн эрхийн тухай зэрэг олон хуульд агуулгын хязгаарлалтыг тогтоосон. Эдгээр хязгаарлалт нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хийгдсэн хэдий ч нэр томьёоны хувьд ерөнхий, тодорхойлолт байхгүй, хамрах хүрээг тогтоогоогүй нь хэтрүүлэн ашиглах нөхцөл үүсгэж болзошгүй бөгөөд шүүмжлэл өрнүүлсэн сэтгүүлчдэд халгаатай заалт болж байна.

2016 оны хоёрдугаар сарын 5-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн “Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал” хэмээх 8 дугаар зүйлээр хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаалах, хүүхэд хамгаалах зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах зохицуулалт орсон нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн нийгмийн дэг журмыг хангах үүднээс хуулиар тогтоосон, зайлшгүй хязгаарлалтын тухай заалтад нийцэж байна.

Манай Улсын хууль тогтоомжид төрийн мэдээллийг заавал дамжуулах үүргийг ногдуулсан хэд хэдэн хуулийн заалт бий.

Түгээхэд үүрэг оногдуулах

- Урьдчилан сэргийлэх мэдээг радио, телевиз болон мэдээллийн бусад хэрэгслээр түүнийг хүлээн авснаас хойш 15 минутын дотор тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлнэ; /Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 15.2/
- Хэвлэл мэдээллийнхэн дайн эхэлсэн буюу дууссан тухай зарлах ёстой; /Дайны байдлын тухай хуулийн 5.4, болон 6.3/
- Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна; /Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5/
- Шуурхай мэдээлэл нийтэд түгээх шаардлага гарсан тохиолдолд өмчийн харьяалал харгалзахгүйгээр хэвлэл, мэдээлэл, холбооны хэрэгсэл ашиглах; /Цагдаагийн албаны тухай 59.1.2/
- Залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах; /Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.1.5/
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хог хаягдлын талаарх үндэсний уламжлал, зан заншил, тэргүүн туршлага, хууль тогтоомжийг сурталчлах; /Хог хаягдлын тухай хуулийн 42.2.3/

- Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүйгээр, саадгүйгээр мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. /Зөрчлийн тухай хуулийн 5.13.3/

Хэвлэл мэдээллийн байгууллагаас тодорхой төрлийн мэдээлэл дамжуулахыг шаардах зохицуулалтыг урвуугаар ашиглаж болно. Бусад оронд ийм шаардлага тавих нь тун ховор тохиолддог боловч хэвлэл мэдээлэл нь нийтийн ач холбогдолтой зүйлийг хангалттай мэдээлдэг. Хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллага нь дээр дурдсан мэдээллийг дамжуулах бөгөөд үүнийг үүрэг болгож оногдуулах шаардлагагүй. Ийнхүү мэдээллийг өргөн түгээх явдлыг үүрэг болгож ногдуулах биш харин бие даасан олон төрлийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар дээрх зорилгыг хангана. Иймэрхүү позитив үүргийг дээр дурдсанчлан буруугаар хэрэглэх нь элбэг тохиолддог. Бие даасан хэвлэлийг дээрх бүрхэг заалтыг хэрэгжүүлээгүй гэсэн үндэслэлээр дарамтлах, хаах явдал гарч болзошгүй.

Нөгөөтээгүүр, төрийн байгууллагууд мэдээлэл дамжуулах эрхээ урвуугаар ашиглаж болзошгүй. Европын Зөвлөлийн Сайд нарын хороо хувийн хэвлэл мэдээллээс илүү үүрэг хүлээх ёстой төрийн хэвлэл мэдээлэлд “заавал нэвтрүүлэх” үүрэг оногдуулахаас болгоомжилдог. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг зөвхөн хуулиар тогтоосон онцгой нөхцөлд албан ёсны мэдээ, мэдэгдэл, мэдээллийг нэвтрүүлэх эсхүл төрийн байгууллагаас гарсан шийдвэрийг мэдээлэх ба төрийн байгууллагад эфирийн хугацааг ийм зорилгоор олгох ёстой гэж заасан.¹⁵ Олон нийтэд түгээх мэдээ нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын редакторын шийдвэрлэх асуудал бөгөөд хуулийн шаардлага байх ёсгүй.¹⁶

Төрөөс хэвлэл мэдээлэлд эрх зүйн үндэслэлгүй хязгаарлалт хийдэггүй бөгөөд Монгол Улсад сэтгүүлчийн мэргэжил эрхлэхэд ямар нэг хориг, саад үгүй. Парламентын болон шүүхийн сурвалжилга хийх сэтгүүлчдээс зөвхөн албан ёсны үнэмлэх шаарддаг. Мөн 1995 онд батлагдсан Онц байдлын тухай хуульд Засгийн газар “...олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох” эрхтэй гэж заасан нь төрөөс хэвлэл нийтлэх эрх чөлөөнд цензур тавих эрсдэлийн нэгээхэн жишээ юм.

Соёлын тухай хуульд 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтөөр “Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт” гэсэн (19) зүйлд нэмэлт оруулсан. Энэ зохицуулалтын гол агуулга нь үндэсний нэвтрүүлгийг дэмжих төрийн бодлоготой уялдаж байгаа ч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт

¹⁵ Зөвлөмж №R (10 (96, тэмдэглэл 44.

¹⁶ “Монгол Улс шилжилтийн үед: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ”, (2002 он), 59 дэх тал

учруулж болзошгүй үүрэг ногдуулалт юм. Зөвхөн улсын байцаагчийн шийдвэрээс хамаарсан олон нийтийн оролцоо, хяналт нь үүргээ урвуулах, хэтрүүлэн ашиглах бололцоог төрд олгодог.

Агуулгад тавих хязгаарлалт

Монгол Улсын хэд хэдэн хуульд нийтлэх болон нэвтрүүлэх зүйлийн агуулгад хязгаарлалт тавьсан байдаг. Ихэнх тохиолдолд хуулиар хууль ёсны зорилгыг хамгаалдаг. ИБУТЭОУП-ын 20 дугаар зүйлээр дайныг сурталчлах, алагчлан дайсагналцах, хүчирхийллийг өдөөн турхирах, арьс өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зэргийг хориглодог. Гэхдээ үүнийг хэт өргөн эсхүл хэт бүрхэг тодорхойлдог учраас буруугаар хэрэглэх бололцоо бүрдэх эрсдэлтэй. Садар самууныг сурталчлахыг хориглосон заалт хэд хэдэн хуульд орсон. Үүнд:

- Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол; /Эрүүгийн хуулийн 16.8/
- “Садар самууныг сурталчлах” гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг; /Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 3.1.1/
- Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол; /Эрүүгийн хуулийн 16.9/
- Дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, соёлд хор хохирол учруулах соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглоно; /Соёлын тухай хууль 19.3/
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно; /Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 5.1/
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, түүний ул мөрийг нуун далдлах арга, хэрэгслийг нарийвчлан дүрсэлсэн, гэмт хэрэг, зөрчлийг ашиг, орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгон харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдэл төрүүлж болох агуулгатай аливаа мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхийг хориглоно; /Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32.6/
- Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь

эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно; /Зөрчлийн тухай хуулийн 5.13.1/

1.8. Бусад зохицуулалт

Хэвлэл мэдээллийн өмчлөл ба төвлөрөл

2010 онд баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх” заалт анх удаа тусгагдсан юм. 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгана”, мөн 30 дугаар зүйлийн 30.1.2 хэсэгт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, хэт төвлөрөл бий болохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх” гэж Харилцаа холбооны зохицуулах хорооны үүрэгт заажээ.

Монгол Улсад бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүртгэлтэй байх ёстой бөгөөд байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор бүртгүүлэх өргөдлөө гаргах үүрэгтэй. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх нь зүйн хэрэг. Монгол Улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл ашгийн болон ашгийн бус гэсэн хоёр үндсэн төрөлтэй хэдий ч хуульд өмчлөлийн олон талт байдлыг тусгаагүй. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бодлого, зохицуулалтыг аль ч түвшинд хүлээн зөвшөөрөөгүй байна. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар шашны байгууллагад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон нь хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хязгаарласан зохицуулалт болсон. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.16.1 дэх хэсэгт заасны дагуу радио, телевизийн байгууллага нь зөвхөн тусгай зөвшөөрөл авсны дараа бүртгүүлэх ёстой. Харин тусгай зөвшөөрөл авахын тулд тухайн засаг захиргааны Засаг даргын саналыг авах шаардлагагүй болгож, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар зохицуулах болсон юм.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар эзэмшил, төвлөрлийн асуудлыг хуульчилсан нь сайшаалтай хэрэг юм. Өмнө нь журмаар зохицуулж байсан харилцааг хуулиар зохицуулах болсон нь дэвшил байлаа. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, хэт төвлөрөл бий болохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх нь ХХЗХ-ны үүрэг юм. Мөн тус хуулийн 7.4.3-д “радио, телевизийн газрын тоон сүлжээний үйлчилгээ болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй давхардуулан олгохгүй, эзэмшил нь тусдаа

байх"-ыг зохицуулсан байна. Хэвлэл мэдээллийн эзэмшил, харьяалал нь компани, хувь хүмүүсийн өөр өөр нэр дээр бүртгэгдсэн тул жинхэнэ эзэмшигчид нь ил тод бус, борлуулалтын мэдээлэл болон хэрэглэгчдийн зах зээлд эзлэх хувийг нууцалдаг учир төвлөрлийг бодитоор тогтоох боломж хомс байна.

2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь хэсэгт хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар зохицуулсан. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд төрийн өмчлөлийг хориглосон ч сүүлийн жилүүдэд орон нутгийн засаг захиргаа үйл ажиллагаа, бодлогоо сурталчлах телевиз, сонин олноор байгуулж, хууль зөрчиж байна. Хэвлэл мэдээллийн өмчлөл нууц байх, хэвлэл мэдээлэл нэг гарт төвлөрөх нь редакцын цензурийг өөгшүүлж, ингэснээр хэвлэлийн эрх чөлөөг боогдуулан, олон ургалч үзлийг сааруулж, сэтгүүл зүйн мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

Хэвлэл мэдээллийн зах зээл бүрэн төлөвшөөгүй, хэвлэл мэдээллийн байгууллагууд зар сурталчилгааны орлогын төлөө шударга өрсөлдөхөөсөө илүү төрийн байгууллага, улс төр, бизнесийн байгууллагатай гэрээ хийж, үйл ажиллагаа явуулж байна. Холбогдох судалгааны дүнгээс дурдахад, Монгол Улсад хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод байдал болон хэвлэл мэдээллийн төвлөрлийн талаар тухайлсан хууль тогтоомж байдаггүй. 2016 онд Хэвлэлийн хүрээлэн Хил хязгааргүй сурвалжлагчид олон улсын байгууллагатай хамтран хэвлэл мэдээллийн эзэмшлийн талаар судалгаа хийсэн. Судалгааны үр дүнгээс харахад Монголын хамгийн их хүртээмжтэй, үзэгч сонсогчдын таашаадаг хэвлэл мэдээллийн хэрэгслийн дийлэнх буюу 74% нь улс төрчид, нийтийн албан тушаалтан, улс төрд ойр байдаг бизнесийн бүлгүүдийн мэдэлд байна.¹⁷ Түүнчлэн 39 хэвлэл мэдээллийн хэрэгслээс 29-ийнх нь эзэн, хөрөнгө оруулагч улс төрийн ямар нэгэн хамааралтай байгаа талаар дурджээ.

Хаалтын гэрээ

Монголын хэвлэл мэдээллийн салбарт далд нуугдсан олон асуудал байгаагийн нэг нь редакцын цензур буюу цагдан хяналт юм. Тухайлбал, "Таны ажилладаг редакцияд хаалтын гэрээтэй эсвэл бусад шалтгаанаар бичихийг хориглосон сэдвийн хар жагсаалт гэж бий юу" гэсэн асуултад нийт оролцогчдын 40 хувь нь "тийм" гэж хариулсан. Мөн 2018 онд хийсэн "Сэтгүүлчдийн аюулгүй байдлын түвшин тогтоох" судалгаагаар 300 сэтгүүлчийг хамруулснаас 52% нь редакцияас зарим асуудалтай холбоотойгоор нийтлэл, нэвтрүүлгийг нь хориглосон тухай дурджээ.

Дээрх дүнгээс үзэхэд хэвлэл нийтлэх эрх чөлөөний хамгийн тулгамдсан

¹⁷ <https://mongolia.mom-rsf.org/mn/translation-context/translation-media-market/>

асуудлын нэг “хаалтын гэрээ” болоод байна. Гэвч хаалтын гэрээ хэмээх тухайлсан гэрээ байдаггүй бөгөөд сурталчилгааны гэрээ, хамтран ажиллах гэрээ дотор байдаг ганцхан заалтыг нэрлэж болно. Тухайлбал, “захиалагч талын нэр хүндэд харшлах аливаа сөрөг мэдээ, мэдээллийг захиалагч талд мэдэгдэх, нэвтрүүлэхгүй байх үүрэг хүлээнэ” гэдгийг хаалтын гэрээ гэдэг нэр томъёогоор ойлгоно. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хаалтын гэрээ байгуулах нь хэвлэл мэдээллийн тэнцвэртэй, чөлөөт байх, олон ургалч, хараат бус байх зарчимтай үл нийцнэ.

Иймдээ ч УИХ-ын Сонгуулийн тухай хуульд хаалтын гэрээг анх удаагаа хориглосон. Тодруулбал, Сонгуулийн тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.7 дахь хэсэгт “Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно” гэснийг хаалтын гэрээ байгуулахгүй гэсэн утгаар ойлгож болохоор байна. Хэрэв энэхүү үүргээ зөрчвөл, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.19-д зааснаар иргэнийг 20,000,000 төгрөгөөр хуулийн этгээдийг 200,000,000 төгрөгөөр торгох хуулийн хариуцлагатай байна. Гэхдээ энэ нь зөвхөн сонгуулийн үеэр хүлээлгэх хариуцлага юм. Хаалтын гэрээтэй холбоотой маргааныг шүүхээс одоогоор хянан шийдвэрлээгүйг shuukh.mn нээлттэй цахим хуудаснаас харж болохоор байна.

Хэвлэлийн мэдээллийн хэрэгслүүд аливаа хэлбэрийн хаалтын гэрээ байгуулах нь эдийн засгийн хараат байдалд оруулдаг. Байгууллагын удирдлага нь тухайн хамтран ажиллагч этгээдийн эсрэг мэдээ, мэдээлэл нийтлэхгүй байх, тийм мэдээлэл бэлдсэн сэтгүүлчийн мэдээ, материалыг засварлах, бүр цаашлаад хориглох тохиолдол байдаг учир энэ нь сэтгүүлч, редакцын хараат бус, бие даасан байдалд ноцтойгоор халддаг юм.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулиараа аливаа хэлбэрийн цензурийг хориглосон. Тодруулбал, тус хуулийн 3 дугаар зүйл 3.1 дэх хэсэгт “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” гэж заасан. Энэхүү заалтад бүх төрлийн цензур хамаарна. Засгийн газраас хэвлэл мэдээллийн зарим байгууллагуудтай “хамтран ажиллах” гэрээ байгуулж байгаа нь төрийн хяналт цензурийг тогтоох эрсдэлтэйгээс гадна олон нийтийн үнэнийг мэдэх эрх ашигт нийцсэн мэдээ, мэдээлэл бэлтгэх үүргээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь умартахад хүргэх аюултай үзэгдэл юм. Угтаа чөлөөт хэвлэл мэдээлэл нь олон нийтийн үнэнийг мэдэх зарчимд үйлчилдэг, хараат бус байх ёстой бөгөөд аль нэг талын дагнасан зар сурталчилгаа, мэдээлэл түгээх нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх биш гэж үзэж болно.

Интернэт

Монгол Улсад хэрэглэгчид дотоод, гадаадын аль ч сайтад нэвтэрч, нийгмийн сүлжээнд нэгдэж, харилцахыг төрөөс хязгаарласан зохицуулалт байхгүй. Нөгөө талаас, Цагдаагийн ерөнхий газар болон ХХЗХ-ны дарга нарын хамтарсан А/200,

А/169 дугаар тушаалаар “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, ил худал мэдээлэл цахим орчинд тараахаас сэргийлэх, зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам”-ыг 2020.08.27-ны өдөр баталж, дагаж мөрдөж байна. Энэхүү журмаар цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээллийг устгах, эсхүл хандалтыг хязгаарлах тухайн цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг цар тахал намдах хүртэл хугацаагаар хязгаарлах зохицуулалтууд орсон.

Журам батлагдсантай холбоотойгоор ХХЗХ-ноос интернэтийн үйлчилгээ эрхлэгчид харилцаа холбооны үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай 2020.11.11-ний өдөр 04/1981 албан тоот хүргүүлж тус журмыг мөрдөн ажиллахыг 290 цахим сайтын үйлчилгээ эрхлэгчдэд анхааруулсан. Үзэл бодлоо илэрхийэх эрхийг ийнхүү нийтлэг байдлаар хязгаарласан нь бүх нийтийн эрүүл мэндийг цар тахлаас хамгаалах зорилгод гарцаагүй шаардлагатай гэж үзэх хууль зүйн үндэслэл хангалттай биш юм. Мөн түүнчлэн, Засгийн газрын 2020 оны гуравдугаар дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаас гарсан чиглэлийн дагуу цар тахалтай холбоотой албаны мэдээ, мэдээллийг хэрэглэгчийн сэтгэгдэл авах боломжгүй тохиргоотойгоор нийтлэх зөвлөмжийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос мөн өдөр 134 цахим сайтын үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн¹⁸. Энэхүү чиглэлийн дагуу захиргааны хэм хэмжээний актаар бүртгэсэн тогтоол, захирамж одоогоор гараагүй тул заавал дагаж мөрдөх хууль зүйн үүрэг цахим сайтын үйлчилгээ эрхлэгчдэд байхгүй юм.

Журмын 4.1.1-д “цахим орчинд цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээ, мэдээлэл тарааж байгаа цахим орчинд хязгаарлалт хийх хүрээнд хамтран ажиллах төлөөлөгч томилж, овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх” гэж заасан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт/цензур/тогтоохгүй”, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно” гэсэн хуулийн заалтуудтай зөрчилдөж байгаа юм.

Олон улсын хэм хэмжээгээр хэвлэл мэдээллийн ажилтнуудад тусгай зөвшөөрөл олгох, бүртгэхийг хориглодог. Сэтгүүл зүй бол мэргэжлийн, бүтэн цагаар ажиллаж буй сурвалжлагч, шинжээч, блогчид, хэвлэл болон интернэт, өөр бусад хэрэгслээр өөрөө хэвлэн нийтлэл эрхлэгчдийг хамарсан өргөн хүрээтэй, олон тооны тоглогчдын дунд хуваагддаг үйл ажиллагаа бөгөөд улсын бүртгэлийн ерөнхий тогтолцоо, сэтгүүлчдийг лицензлүүлэх нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд үл нийцнэ. Хязгаарлагдмал итгэмжлэх үнэмлэх олгох нь тодорхой газар, үйл явдалд нэвтрэх давуу эрх олгож байгаагаар зөвшөөрөгдөнө. Ийм зохион байгуулалт нь Пактын 19 дүгээр зүйл, Пактын бусад зүйл заалтад нийцсэн, үл ялгаварлах зарчим, бодит шалгуурт үндэслэгдэх бөгөөд

¹⁸ Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим сайт, Цахим сайтын үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлэх тухай мэдээлэл.

сэтгүүл зүй бол өргөн хүрээтэй, олон тооны тоглогчдын дунд хуваагддаг үйл ажиллагаа болохыг анхааралдаа авах ёстой.

Иргэд зохих шаардлага хангахгүй, эсхүл интернэт холболтгүй орчинд тусгаарлагдсанаар гэр бүл, найз нөхөдтэйгээ харилцах, мэдээлэл олж авах, цахим сургалтад хамрагдах зэрэг мэдээлэл, харилцааны боломж давхар хязгаарлагдаж байна. Тухайлбал тусгаарлан ажиглах байрны бүх өрөөнд зурагт радио байхгүй, хурд багатай интернэтийн сүлжээ ашиглах зэрэг нь иргэдийн мэдээлэл авах эрхийг хөндөж, бухимдлыг төрүүлж байгаа талаар ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь удаагийн илтгэлдээ онцлон дурджээ.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт

Монгол улсад анхны өөрийн зохицуулалтын байгууллага болох Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр албан ёсоор байгуулагдсан. Хэвлэл мэдээллийн зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөл удирдах бөгөөд телевиз, радиогийн ёс зүйн хороо (15 хүн), сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороо (15 хүн), ажлын алба, гүйцэтгэх захиралтай үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн таван жилд ХМЗ-ийн үйл ажиллагаа өргөжин тэлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас тус зөвлөлд өргөдөл гомдол гаргах нь нэмэгдэж байна. Тухайлбал, 2015 онд 19 хэвлэл мэдээллийн редакцад хаягласан өргөдөл гомдлыг хүлээж авч шийдвэрлэсэн бол 2018 онд 100, 2019 онд 106 хүлээн авч шийдвэрлэжээ. Харин Ковид-19 цар тахлын хорио цээрийн дэглэм хэрэгжиж байсан 2020 онд 52, 2021 онд 72 өргөдөл, гомдол хүлээн авч ёс зүйн хороод хэлэлцэн шийдвэрлэжээ. Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулагдсан цагаасаа хойш иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас сэтгүүл зүйн ёс зүйн зарчмыг зөрчсөн гэж үзсэн нийт 483 /2022 оны 4 сарын 20-ны өдрийн байдлаар/ гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Эндээс дүгнэвэл, жилээс жилд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөр маргаанаа шийдвэрлүүлэх гэсэн өргөдөл, гомдлын тоо өсөж байгаа дүр зураг харагдаж байгаа нь түүний нийгэмд хүлээн зөвшөөрөгдөж буй хэрэг юм.

Хэвлэл мэдээллийн зөвлөл нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага (НҮТББ)-ын дүрэм, Үйл ажиллагааны журам, Гомдол хүлээн авах, барагдуулах журам, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тулгуурлан өргөдөл гомдлыг хэлэлцэж дүгнэлт гаргадаг.

2021 онд иргэд, байгууллагаас ирүүлсэн нийт 72 өргөдөл гомдол нь:

- Радио, телевизийн Ёс зүйн хороонд 11 (15%)
- Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хороонд 61 (85%) тус тус хаяглагджээ.




ХМЗ-өөс өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал:

Гомдол хүлээн авах, барагдуулах журам (цаашид ГХАБЖ гэх)-ын 2.3-ийн дагуу 25 редакцад хаягласан гомдлыг хугацаа хэтэрсэн, материалаа бүрэн бүрдүүлж өгөөгүй, Зөвлөлийн чиг үүрэгт хамаарахгүй, гомдол үндэслэлгүй зэрэг шалтгаанаар тус Зөвлөлийн Ажлын албанаас урьдчилсан хяналт хийж шийдвэрлэсэн байна. Харин 7 редакцад хаягласан өргөдлийг гомдол гаргагч өөрөө буцаан татсан. Ингээд сэтгүүл зүйн 40 бүтээлд хаягласан гомдлыг Ёс зүйн хоёр хорооны зургаан удаагийн хуралдаанаар сэтгүүл зүйн ёс зүйн зарчмыг зөрчсөн, эс зөрчсөн талаар нягтлан хэлэлцэж, ГХАБЖ -ын 6.3-ийн дагуу дараах дүгнэлтийг гаргасан.

1. ГХАБЖ -ын 6.3.1-ийн дагуу **17** редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчөөгүй гэдгийг олон нийтэд мэдээлэх;
2. ГХАБЖ -ын 6.3.2-ын дагуу **9** редакцыг зөрчлөө өөрсдөө залруулсан, уучлал гуйсныг мэдэгдэж, нэрийг дурдахгүйгээр олон нийтэд мэдээлэх;
3. ГХАБЖ-ын 6.3.3-ын дагуу **14** редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчсөн тул нэрийг дурдаж олон нийтэд мэдээлэх зэрэг болно.

Ёс зүйн хороодын дүгнэлтээс харахад хариуцагч хэвлэл мэдээллийн редакцууд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.1-т заасан “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ” гэсэн заалтыг нийтлэг байдлаар зөрчжээ.¹⁹

¹⁹ <http://www.mediacouncil.mn/>



ХОЁР

ҮЗЭЛ БОДЛОО
ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ
ЧӨЛӨӨНИЙ НӨХЦӨЛ
БАЙДАЛ



Глоб Интернэшнл төвөөс Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ болох өндөржүүлсэн бэлэн байдал болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн 2020 оны 1 дүгээр сарын 27-ноос 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хамрах хугацаанд гарсан иргэний болон улс төрийн эрхийн зөрчилд, тухайлбал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдэх эрх, эвлэлдэн нэгдэх, тайвнаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийн зөрчилд мониторинг хийв. Энэхүү мониторингийн дүнг хавсралтаар танилцуулж байна.

Глоб Интернэшнл төв нь 2021-2022 оны хооронд иргэн, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын 100 гаруй ажилтанд хууль, эрх зүйн зөвлөгөөг үнэ төлбөргүйгээр үзүүллээ. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн асуудлаар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл, гомдол гаргаснаар Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан болж 05 дугаар дүгнэлт²⁰ гарсан маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцсон.

Иргэний хуулийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг сэргээлгэх нэхэмжлэлтэй 4 иргэний хэрэгт өмгөөлөгчөөр ажиллаж шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэв. Эрүүгийн хуулийн Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт холбогдуулан шалгагдсан 11 хэвлэл мэдээллийн байгууллагын 13 эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцож шүүхийн өмнөх шатанд хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн байна.

Эрх зүйн зөвлөгөөг төрлөөр нь авч үзвэл цар тахлын үед мэдээ, мэдээлэл бэлтгэсэнтэй холбоотойгоор Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар цагдаагийн байгууллагад шалгагдсан зөрчил дийлэнх хувийг эзэлж байна. Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйл Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих зөрчил шалган шийдвэрлэх 2 ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцов. Мөн Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйл "...олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн..." үндэслэлээр 500,000 төгрөгөөр торгуулсан иргэн М-ийн шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрч Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргаснаар шүүх хурал 2021.06.04-ний өдөр болж, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож шийдвэрлэсэн. Тус иргэнийг Энхсаран сувилалд хэвтэн эмчлүүлж байхдаа Эрүүгийн хуулийн 15.6 дугаар зүйл Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин халдаах гэмт хэрэгт буруутган мөрдөн ажиллагаа

²⁰ 2021.05.19-ний өдрийн 05 дугаар дүгнэлтээр "Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт "Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;" гэж заасныг тус тус зөрчөөгүй байна. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай." хэмээн шийдвэрлэсэн. Дэлгэрэнгүйг эндээс үзнэ үү. <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16230812118891>

явуулж, шүүхэд шилжүүлж, шүүхээс нэмэлт хэрэг бүртгэл, мөрдөн шалгах ажиллагаанд буцаасны үр дүнд улмаар хэргийг хэрэгсэхгүй болгох Поукурорын тогтоол гарч шийдвэрлэгдсэн байна.

Глоб Интернэшнл төв сэтгүүлчдийн мэргэжлийн эрхэд халдсан дараах зөрчлийг онцолж байна.

Зөрчил 1. Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчиж жагсаал, цуглаан зохион байгуулсан гэх үндэслэлээр шийтгэл оногдуулав.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хүрээнд:

Комедиан Амартүвшин, иргэн Д.Булгантамир нарыг 2021.06.28-ны өдөр Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчиж жагсаал, цуглаан зохион байгуулсан гэх үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 5.13.2 дахь хэсэгт заасны дагуу 500,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан. Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс 2022.01.11-ний өдөр шийтгэлийн хуудсыг хэрэгсэхгүй болгож эцэслэн шийдвэрлэв.

Зөрчил 2. Сэтгүүлчийг нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан хэмээн Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргав.

Сэтгүүлчийг нэр төр, алдар хүндэд халдсан хэмээн Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Хөвсгөл аймгийн Хөвсгөл ард түмний телевизийн сэтгүүлч Ж.Эрдэнэцэцэг болон аймгийн засаг дарга, нэр бүхий төрийн албан хаагчид холбогдуулан тус аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд иргэн С.Ч нь нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээлгэхээр нэхэмжлэл гаргасан. Шүүх хуралдаан 2021.12.13-ны өдөр болж "Бүрэн гүйцэд мэдээлээгүй, бодит мэдээлэл өгөөгүй, буруу мэдээлэл тараасан гэж Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга асан С.Ч-гээс уучлалт гуйлгахыг даалгах тухай" нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Энэхүү хэрэгт хүний хувийн орон зай, хувь хүнийх нь нэр төр, алдар хүндийг гутаасан үйлдэл огт гаргаагүй, нэр хоч өгөх зэргээр доромжилсон шинжтэй үйлдэл байхгүй бөгөөд болсон үйл явдлыг баримтад үндэслэн эх сурвалжийг оролцуулж нийтийн албан тушаалтантай холбоотой мэдээллийг бэлтгэснээрээ сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа хараат бусаар бэлтгэн явуулж чадсанаараа онцлог юм.

Зөрчил 3. Үзэл бодлоо илэрхийлж, “шүгэл” үлээсний төлөө Зөрчлийн тухай хуулиар торгосныг Шүүхээс хүчингүй болгож, Эрүүгийн хэрэгт яллагдагчаар татсан тогтоолыг Прокуророос хэрэгсэхгүй болгож тус тус шийдвэрлэв.

Үзэл бодлоо илэрхийлж, “шүгэл” үлээсний төлөө Зөрчлийн хуулиар торгож, Эрүүгийн хуулиар яллагдагчаар татав.

Иргэн Д.М нь Энхсаран сувилалд хэвтэн эмчлүүлж байхдаа коронавирусийн халдвар авсан болох нь 4 дэх шинжилгээгээр тогтоогддог. Иргэн нь 2020.11.10-ны өдөр өөрийн цахим хуудсаараа дамжуулан халдвар хамгааллын дэглэм муу, ариун цэвэр хангалтгүй, хулганаар дамжин халдвар тархах эрсдэлтэй байгааг анхааруулсан. Улмаар 2020.11.11-ний өдөр ЗГ-ын 178 дугаар тогтоолоор бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн. 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн ЦЕГ-ын НХЖОНАБА-ны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн эрх бүхий албан тушаалтан нь Зөрчлийн тухай хуулийн 5.13.1 дэх заалтаар торгох шийтгэл оногдуулсан. Шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрч Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргаснаар шүүх хурал 2021.06.04-ний өдөр болж, шийтгэлийг хуудсыг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Мөн Хан-Уул дүүргийн Прокурорын газраас 2021.03.24-ны өдөр иргэн Д.М-ийг Эрүүгийн хуулийн 15.6.1 дэх хэсэг Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин бусдад халдаах, эсхүл тархах нөхцөл бүрдүүлсэн зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан. Энэхүү хэргийг шүүхэд шилжүүлснээр шүүхээс нэмэлт хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтад буцааж улмаар хэргийг хэрэгсэхгүй болгох тухай 2021.12.17-ны өдөр прокурорын тогтоол гарч шийдвэрлэсэн байна. Эрүүгийн хуулийн 15.6 дугаар зүйлийн 15.6.1 дэх заалт нь Цар тахлын тухай хууль батлагдсантай холбоотойгоор 2020.04.29-ний өдөр нэмэлт өөрчлөлт орж гэмт хэрэгт тооцогдох болсон. Иргэн Д-тэй холбоотой Эрүү, Зөрчлийн хэргүүд нь иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээс гадна төрийн байгууллагаас цар тахалтай холбоотойгоор гаргасан алдаа, дутагдлаа иргэнээс хайсан үйлдэл болсон юм.


Зөрчил 4. Төрийн өндөр албан тушаалтан²¹, улс төрд нөлөө бүхий албан тушаалтан²² болон төрийн, төрийн өмчит хуулийн этгээдээс хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн эсрэг Цагдаагийн байгууллагад гомдол, мэдээлэл, Шүүхэд нэхэмжлэл гаргах хандлага түгээмэл байна.

Өнгөрсөн 1 жилийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын шадар сайд, Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, Улсын Дээд Шүүхийн шүүгч, зарим УИХ-ын гишүүн, яам, агентлагийн сайд дарга нар, нэр бүхий аймгийн засаг дарга болон аймгийн прокурорын газруудаас хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд, түүнчлэн нийгмийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийн эсрэг гомдол, нэхэмжлэл гаргах үзэгдэл нийтлэг байна. Энэ нь эрх зүйн орчин боловсронгуй бустай холбоотой юм. Эрүүгийн хуулийн Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт холбогдуулан төрийн байгууллага, улс төрд нөлөө бүхий этгээдийн хувь хүнийх нь нэр төрд халдсан бус, зөвхөн эрхэлж буй албан тушаалтай нь холбоотойгоор нийтэлсэн мэдээлэлд гомдол гаргах эрхгүй байх зохицуулалт байхгүй байна. Иргэний хэрэгт нэхэмжлэл гаргаж буй этгээд өөрийн буруугүйг нотлох баримтыг шүүхэд ирүүлэх үүрэг байхгүйн улмаас ялангуяа сонгуулийн жилүүдэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо өндөр байна. Дээрх иргэн, хуулийн этгээдийн гаргасан гомдол, нэхэмжлэл нь *isee.mn*, *ulsturch.mn*, *eguur.mn*, *ergelt.mn*, *zarig.mn*, *tsahiur.mn*, *tac.mn*, *gogo.mn* зэрэг сайтууд, Хөвсгөл аймгийн Хөвсгөл ТВ, Дарханы DBS ТВ, Төв аймгийн Төв ТВ, Улаанбаатар хотын Live ТВ, Өглөөний сонин, Өдрийн сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудын эсрэг гаргасан бөгөөд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаануудад татагдан оролцоод буй юм.

²¹ Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн өндөр албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай УИХ-ын 2019.02.01-ний өдрийн 19 дугаар тоот тогтоолтой эндээс танилцана уу. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389818987771&showType=1>

²² Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.5-д "Улс төрд нөлөө бүхий этгээд" гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т "Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй" гэж тус тус зохицуулсан.



ГУРАВ

**СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙНЭСРЭГ ИРГЭНИЙ
БОЛОНЭРҮҮГИЙНХЭРЭГ**



Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эдийн бус гэм хорын хохирол учруулсантай холбоотойгоор 2021 онд иргэний хэргийн шүүхээс шийдвэрлэгдсэн 54 хэрэг байна. Нээлттэй цахим сан болох Shuukh.mn сайтаас эдийн бус гэм хорыг арилгах, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой анхан шатны 29, давж заалдах шатны 9, хяналтын шатны 2, нийт 40 шүүхийн шийдвэрийг байршуулсан байна.

Шүүхээс шийдвэрлэгдсэн хэрэгт нэхэмжлэл гаргагчдын 30% нь төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага байгаа бол 22.5% нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг хариуцагчаар тодорхойлсон нэхэмжлэл байгаа юм.

Нэхэмжлэгч талаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад гаргаж буй эдийн бус гэм хорыг арилгах хохиролд ойролцоогоор 13,650,000 /арван гурван сая зургаан зуун тавин мянган/ төгрөг нэхэмжилсэн байна.

Эрүүгийн хуульд 2020.01.10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулснаар 13.14 дүгээр зүйлээр “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг шинээр нэмсэн. Худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотойгоор 2021 онд шийдвэрлэгдсэн 15 хэргийн хоёр нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн эсрэг гаргасан гомдол байна. Үүний нэгд нь УИХ-ын гишүүнээс гаргасан гомдлын дагуу эрүүгийн хэрэг үүсэж, улмаар сэтгүүлчийг нэг сая төгрөгөөр торгох ял оногдуулж шийдвэрлэсэн бол, үлдсэн нэгд нь нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр хэргийг прокурорт буцаажээ. Эрүүгийн хэргийн хувьд шүүхээс оногдуулсан мөнгөн торгуулийн дээд хэмжээ нь 1,300,000 төгрөг байв. Мөн энэхүү хэрэгт шалгагдаж байх хугацаандаа таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж, 2-11 хоногийн хугацаатай цагдан хоригдсон тохиолдлууд гарсан бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу цагдан хоригдсон нийт хугацааг торгох ялын дүнгээс хасаж, 835,000 төгрөгийн торгох ял иргэнд оногдуулсан байна.

1999-2021 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд болон гүтгэлэг, доромжлол, илт худал мэдээлэл тараахтай холбоотой шүүхээс шийдвэрлэгдсэн нийт 1146 иргэний болон эрүүгийн хэргийн 42% сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдож байна.

1999-2021 оны хэргийн харьцуулсан үзүүлэлт

Он	Иргэний хэрэг		Эрүүгийн хэрэг	
	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах
1999	30	-	3	-
2000	39	-	-	-
2001	31	11	4	-
2002	44	37	2	2
2003	28	18	1	1
2004	40	40	1	1
2005	29	25	1	1
2006	36	31	3	3
2007	33	33	-	-
2008	39	25	5	5
2009	44	17	1	-
2010	67	37	2	-
2011	43	23	7	3
2012	43	20	8	4
2013	37	17	9	3
2014	45	20	12	9
2015	37	10	14	5
2016	47	12	9	1
2017	49	12	5	0
2018	69	19	0	0
2019	36	11	1	0
2020	106	14	17	1
2021	54	10 ²³	15	2
Нийт	1026	442	120	41

²³ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн албан тоотод нийт шийдэгдсэн 54 хэрэг маргаанаас хэд нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой талаарх дэлгэрэнгүй статистик мэдээлэл хөтөлдөггүй талаар дурдсан.

Хавсралт 1. Ковид-19 цар тахлын үе дэх иргэний болон улс төрийн эрхийн зөрчлийн мониторинг (2020.11.20-2022.03.31)

1. МОНИТОРИНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Мониторингийн зорилго:

Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ нь олон улсын хүний эрхийн хязгаарлалтын зарчимд нийцэж буй эсэхийг үнэлэх, цар тахлын үед мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэхэд нөлөөлөхөд оршино.

Мониторингийн үйл ажиллагаа:

Мониторингийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдэх эрх, тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний үед буюу өндөржүүлсэн бэлэн байдлын үе болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд зөрчиж буй үйлдлийг тухай бүр бүртгэх, түүнд дүн шинжилгээ хийх, зөрчлийн мөрөөр хариу нөлөөллийн үйл ажиллагаа явуулах ажлыг 2020 оны 11 сарын 20-оос 2022 оны 3 сарын 31-ний хугацаанд 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ.

Мониторингийн арга зүй:

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдэх эрх, тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний үед буюу өндөржүүлсэн бэлэн байдлын үе болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд зөрчиж буй эсэх тохиолдлыг бүртгэх, түүнд үнэлгээ өгөхдөө Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлээс гадна Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйл, тус Пактын 34, 37 дугаар ерөнхий тайлбарыг баримталж, холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтад дүн шинжилгээ хийв.

Мониторингийн хамрах хугацаа:

Мониторингийг Монгол Улсад Ковид-19 буюу цар тахлын эсрэг хариу арга хэмжээ болох өндөржүүлсэн бэлэн байдал болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын



31-ний өдрийг хамруулан хийсэн юм.

Мониторингийн 1 дүгээр үе шатанд зөрчлийг зөвхөн төрлөөр нь ангилан тооны хувьд бүртгэж байсан бол хоёрдугаар үе шатнаас арга зүйг шинэчлэн дараах хүснэгтийн дагуу зөрчлийн мэдээллээ бүртгэсэн болно.

№	Агуулга
1	Зөрчлийн утга. Энд зөрчлийн утга болон зөрчлийн огноо, зөрчил гаргагч /албан тушаалтан; иргэн; бусад/, зөрчлийн хохирогч /иргэн; сэтгүүлч; бусад/, зөрчлийн байршлын /Улаанбаатар; орон нутаг/ мэдээллийг товч, тодорхой бичнэ.
2	Зөрчсөн хууль тогтоомж. Энд зөрчсөн хуулийн нэр, зүйл, хэсгийг бичнэ.
3	Зөрчлийн төрөл. Энд тухайн зөрчил нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдэх эрх, тайван жагсаал, цуглаан хийх эрхийн алийг зөрчсөн болохыг бичнэ.
4	Мэдээллийн эх сурвалж. Энд тухайн зөрчлийн эх сурвалж нь иргэний; сэтгүүлчийн; албаны; нээлттэй мэдээллийн аль нь болохыг бичнэ.
5	Зөрчлийн шалтгаан. Энд тухайн зөрчил нь эрх зүйн акт хангалтгүй; зөрчил гаргагчийн мэдлэг, чадвар хангалтгүй байгаатай холбоотой эсэх, зориуд гаргасан эсэхийг бичнэ.


2. ЦАР ТАХЛЫН ҮЕД ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХЭД ХАЛДСАН ЗӨРЧИЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д баталгаажуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, тайван жагсаал, цуглаан хийх эрх, 16 дугаар зүйлийн 17-д баталгаажуулсан мэдэх эрхийн зөрчлийг дээрх байдлаар гурав ангилан танилцуулж байна.

Мониторингийн хамрах хугацаанд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д баталгаажуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн 64 зөрчил, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчсөн 55 зөрчил, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д баталгаажуулсан мэдэх эрхийг зөрчсөн 114 зөрчил, нийт 233 зөрчил байна.

График-1


Иргэний болон улс төрийн эрхийн зөрчлийн эзлэх хувь



Арга зүй хэсэгт дурдсанчлан хоёр, гуравдугаар үеийн мониторингийг шинэчилсэн, илүү нарийвчилсан арга зүйгээр хийсэн бөгөөд нийт мониторингийн хугацаанд 233 зөрчил бүртгэснээс нэгдүгээр үе шатанд 76 зөрчил, хоёрдугаар үе шатанд 111 зөрчил, гуравдугаар үе шатанд 46 зөрчил бүртгэгдсэн байна.


Ижил арга зүйгээр хийсэн хоёрдугаар үе болон гуравдугаар үе шатанд нийт 157 зөрчил бүртгэснээс 84 хувь нь Улаанбаатар хотод, 14 хувь нь орон нутагт гарчээ.

График-2



Нийт зөрчлийн 133-ыг албан тушаалтан гаргасан бол 18-ыг иргэн, 5-ыг нь аж ахуйн нэгж, үлдсэн 1-ийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйлдсэн байна.


График-3



Зөрчлийн шууд хохирогчийн 117 нь иргэн, 39 нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан байгаа бол үлдсэн 1 нь аж ахуйн нэгж байна.

График-4


Зөрчлийн шууд хохирогч



Дээрх 157 зөрчлийн талаарх мэдээллийн 18 хувь нь албан мэдээлэл, 31 хувь нь иргэний мэдээлэл, 51 хувь нь сэтгүүлчийн мэдээллийн дагуу бүртгэгдсэн байна. Зөрчлийн шалтгаан, сэдэлтийг авч үзвэл, 83 нь зориуд гаргасан зөрчил бол, 36 нь эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус, 38 нь түүнийг хэрэглэх мэдлэг, чадвар хангалтгүй байгаатай холбоотой гарсан зөрчил байв.

График-5

Зөрчлийн шалтгаан, сэдэлт



Харин зөрчлийн хор уршгийг 1-3 оноогоор дүгнэхэд, 1 оноотой буюу хөнгөн зөрчил 10, 2 оноотой буюу хүндэвтэр зөрчил 41 бол, 106 нь 3 оноотой буюу хүнд зөрчилд хамаарч байна.

2.1. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн байдал

Мониторингийн эхний үе шат буюу 2020.01.27-2021.02.25-ны хугацаанд гарсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан зөрчлийг мэдээллийн агуулгаар нь багцалбал дор дурдсан тохиолдол багтаж байна:

- 2020.11.18-ны өдөр цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэн Б.Навчаад Эрүүгийн хуулийн 13.14-р зүйлээр яллах дүгнэлт үйлдсэн. Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын гомдлоор үүссэн нэр бүхий иргэний болон сэтгүүлчийн эсрэг гаргасан эрүүгийн хэргүүдийн нэг юм.
- 2020.11.11-ний өдөр Харилцаа холбооны зохицуулах хорооноос цахим хуудсуудад коронавирусийн халдвар, тархалтын талаарх мэдээ мэдээллийг хэрэглэгчийн сэтгэгдэл авах боломжгүй тохиргоотойгоор нийтлэх, холбогдох зөрчил гаргавал Монгол улсаас хандах хандалтыг хязгаарлах хүртэл арга хэмжээ авах нөхцөл бүрдэхийг мэдэгдсэн. Энэ нь тус хорооноос вэб сайтын үйлчилгээ эрхлэгчдэд ковид19-ийн талаарх мэдээллийн агуулгад цензур тогтоох нөхцөл болсон.
- Цахим орчинд өөрийн фейсбүүк хуудсаар дамжуулан үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийг торгосон, сүрдүүлсэн тохиолдлууд. Тухайлбал, 2020.11.19-ний өдөр цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэн иргэнийг 500 мянган төгрөгөөр торгосон, Хотын даргыг цахим орчинд шүүмжилсний төлөө Т.Хаянхярваагаас цагдаа тайлбар, мэдүүлэг авсан.
- 2021.01.02-ны өдөр Тусгаарлалтад байсан иргэд групп чат үүсгэн харилцахыг хориглосон тохиолдол.
- 2021.01.09-ний өдөр олны танил залуус өөрийн нийгмийн сүлжээний хуудсаар үзэл бодлоо илэрхийлсэн пост нийтэлснийг хориглосон тохиолдлууд. Тухайлбал, цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсний төлөө Д.Амартүвшинд “олон нийтийг үймээн самуунд уриалж болохгүй” гэж сануулж тайлбар авсан.
- 2021.01.18-ны өдөр “Энхсаран” сувилалд тусгаарлагдаж байсан иргэн Д.Мөнхбатыг “олон нийтийг төөрөгдүүлэх” худал мэдээ тараасан үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 5.13.1 дэх заалтаар 500,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсныг Хан-Уул дүүргийн эрүүгийн анхан шатны шүүхээс 2021.06.04-ний өдөр хүчингүй болгож шийдвэрлэсэн. Энэ нь цар тахлын үед үзэл бодлоо илэрхийлж, худал мэдээлэл тараах гэмт хэрэгт шийтгэгдсэн хүмүүс шүүхэд хандаж эрхээ сэргээлгэх шаардлагатай болохыг харуулж байна.

Мониторингийн хоёр дахь үе шат буюу 2021.02.25-2021.09.30-ны хугацаанд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн 22 тохиолдол бүртгэгджээ. Эдгээр

зөрчлөөс нийтэд хамааралтай асуудлаарх зөрчлийг авч үзье.

- 2021.04.10-ны өдөр “Вакцин тарихгүй байж ямар ч утгагүй 14 хоног яах гэж хөл хорих гээд байгаа юм бэ, вакцинжуулалтыг зогсоосноо албан ёсоор мэдэгдвээс шууд жагсацгаая” хэмээн шүүмжилж твиттерийн хэрэглэгч бичсэний төлөө цагдаагаас дуудаж тайлбар авсан, зөрчлийн хэрэгт шалгасан.
- 2021.04.29-ний өдөр Сүхбаатарын талбайд амны хаалттай хоёр эмэгтэй зургаа авч “Нам бус залуусын нэгдэл” нэртэй фейсбүүкийн группт “Ямар ч байсан ирлээ. Талбай тойроод цагдаа нар зогсжээ. Ирсэн хүмүүсийг бүгдийг хөөсөн л байхдаа...” гэж нийтэлсний төлөө жагсаалд өдөөн турхирсан гэсэн зөрчлөөр 100 мянган төгрөгөөр торгосон.
- 2021.05.15-ны өдөр “Олон нийтийн газар хог хаясан” гэж иргэнийг 10 мянган төгрөгөөр торгосон байх бөгөөд “Торгуулийн хуудас нь хог хаясан гэж бичсэн байх юм. Савхны гадна талын хуруун чинээ цаасыг ч хүртэл хаяхгүй гэж халаасалж, энэ байна гээд гаргаад үзүүлтэл авч хэлэлцэхгүй л торгууль бичээд 10 мянган төгрөг авлаа даа” гэж фейсбүүкт мэдээлсэн иргэнийг цагдаагийн байгууллага худлаа мэдээлэл түгээсэн тул шалгаж байна гэж албан ёсны хуудастаа мэдээлсэн. Энэ нь цагдаагийн байгууллагыг шүүмжилсэн дуу хоолойг барих гэсэн оролдлого юм.
- 2021.06.24-ний өдөр Сүхбаатарын талбай дээр очиж жагсаал цуглаан зохион байгуулахыг уриалсан иргэн Э.Одбаярын гэрт цагдаагийн албан хаагчид очиж хууль бус шаардлага тавьсан.
- 2021.06.24-ний өдөр хоолны газрууд үр дүнгүй хорихыг эсэргүүцэж заалаар үйлчлэхээ мэдэгдсэнд эрх бүхий байгууллагаас торгууль оногдуулсан.
- 2021.07.09-ний өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хэвлэлийн бага хурал хийж олон нийтэд албан мэдээлэл өгөх үедээ эвлэлдэн нэгдэж тайван замаар цуглаан хийж цалин нэмэхийг шаардаж буй эмч нарыг эх орноосоо урвах гэмт хэрэгт буруутгасан. Тодруулбал, тэрээр эрүүл мэндийн салбарынхантай уулзаж, нээлттэй дамжуулсан мэдээллийн үеэр “Энгийн үед тангараг яриад, ийм үед зовлон ярьж болохгүй. Ийм үед бид эцсийн мөч хүртлээ иргэдээ хамгаалах ёстой. Үүнийг зохион байгуулалттайгаар хийж байгааг тусгай албаны шугамаар олж мэдсэн. Шаардлагатай бол улс эх орноосоо урвасан гэж үзэх болно.» гэж хэлсэн нь тайван жагсаал, цуглаан хийх эрхээ эдэлж буй иргэдийг Эрүүгийн хуулийн ноцтой заалтаар сүрдүүлсэн явдал юм.
- 2021.07.10-ны өдөр Дархан-Уул аймгийн эмч өөрийн твиттер хуудастаа улаан бүсийн нөхцөл байдал, эмч нарын ажлын нөхцөл зэрэг асуудлаар тогтмол бодит мэдээлэл хүргэж байгаад саад хийх зорилгоор албаны



дарга нь “сошиалд даруухан, дуугүй байна уу” гэсэн сануулга өгчээ.

- 2021.09.09-ний өдөр резидент эмч нарыг үзэл бодлоо илэрхийлсний төлөө Эрүүл мэндийн яамны мэргэжилтэн “Нэрээ хэл, хэдэн ч удаа дайчилсан гэсэн явах ёстой, хэрвээ явахгүй гэвэл суралцах эрхийг хасна, цалин олгохгүй, тойролт хийлгэхгүй” гэх зэргээр заналхийлсэн.
- 2021.09.28-ны өдөр #NoDoubleStandard иргэдийн хөдөлгөөн 11 дэх өдрөө үргэлжилж, талбай дээр үзэл бодлоо илэрхийлэхээр ирсэн иргэдийн нэр болон холбогдох мэдээллийг цагдаагийн албан хаагчид бүртгэж байна.
- 2021.09.28-ны өдөр Сэтгүүлч Ц.А-гийн УИХ-ын гишүүний бэлгийн хүчирхийллийн асуудлаар бэлтгэсэн мэдээлэлтэй нь холбогдуулан гэр бүлийн гишүүдийг нь цахим орчинд хуурамч хаяг ашиглан сүрдүүлсэн. Эрүүгийн хуулийн 14.3 дахь хэсэгт “Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол ...” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.

Мониторингийн гурав дахь үе шат буюу 2021.10.01-2022.03.31-ний хугацаанд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн 18 тохиолдол бүртгэгджээ. Эдгээр зөрчлөөс нийтэд хамааралтай асуудлаарх зөрчлийг авч үзье.

- 2021.10.29-ний өдөр иргэн н.Дөлгөөн, н.Жаргалсайхан нарыг үзэл бодлоо илэрхийлж талбайд жагсана гэж мэдэгдсэний төлөө гэрээсээ гарч байхад нь хүч хэрэглэн албадан саатуулсан. Ингэхдээ биед нь халдаж гэмтэл учруулсан.
- 2022.01.12-ны өдөр “Угаартаж үхлээ” гэх бичвэртэй хуудас барьж Улсын Их дэлгүүрийн орчим зогссон залууг зөвшөөрөл авалгүй жагссан гээд цагдаагаас дуудаж, авч явсан байна. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар нэг иргэний үйлдлийг жагсаал, цуглаанд хамааруулж үзэхгүй.
- 2022.01.30-ны өдөр “Сонго-Уйл” уран сайхны киног кино театр болон IPTV-ээр гаргахаас татгалзсан. Уран сайхны арга хэлбэрийг ашиглан үзэл бодлоо илэрхийлэх нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 19 дүгээр зүйлээр хүлээн зөвшөөрөгддөг.

2.2. Мэдэх эрхийг зөрчсөн байдал

Мониторингийн эхний үе шат буюу 2020.01.27-2021.02.25-ны хугацаанд мэдэх эрхийг хязгаарласан зөрчлийг агуулгаар нь багцалбал:

- Иргэд эмнэлгийн тусламж авах зорилгоор төрийн байгууллагын 103, 119 зэрэг дугааруудад холбогдоход тодорхой хариу өгөхгүй, бие бие рүүгээ дамжуулах, утсаа авахгүй байх зэрэг тохиолдлууд ихээр гарав. Үүнээс үүдэн яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадахгүй болох, коронавирусээс бусад эрүүл мэндийн асуудлаар үйлчилгээ авахад хүндрэлтэй байв.
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд заавал машиндаа QR код авч зорчихыг шаардах, хэвлэл мэдээллийн байгууллагуудад QR код авахад нь үндэслэл, тайлбаргүйгээр квот тогтоох
- Эрүүл мэндийн яамнаас мэдээлэл авахаар нэвтрэх сэтгүүлчдийн тоог хязгаарлах
- Төрийн байгууллагаас өгч буй мэдээлэл иргэдэд ойлгомжтой бус, хоорондын уялдаа холбоогүй шалтгаанаар иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирч буй тохиолдлууд
- PCR-ийн шинжилгээ хийлгээгүй иргэдэд төрийн байгууллага үйлчилгээ үзүүлэхгүй байх тухай мэдэгдэл
- Зөвхөн албаны эх сурвалжаас мэдээлсэн, бэлтгэсэн мэдээлэл түгээхийг шаардах
- Мэдээ, мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байхаар зохицуулсан Засгийн газрын 2021.02.10-ны өдрийн 29 дүгээр тогтоол
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд мэргэжлийн үүргээ гүйцэтгэхэд нь дарамт, шахалт үзүүлэх байдал газар авсан.

Мониторингийн хоёр дахь үе шат буюу 2021.02.25-2021.09.30-ны хугацаанд мэдэх эрхийг зөрчсөн 56 тохиолдол байна. Эдгээр зөрчлөөс нийтэд хамааралтай асуудлаарх онцлох зөрчлийг авч үзье.

- 2021.04.02-ны өдөр вакцин хийж эхэлснээс 23 хоногийн дараа вакцинд хамрагдах дарааллыг иргэдийн шахалт, шаардлагын дагуу хэвлэлийн төлөөлөгчид агуулгаар нь ил болгосон. Гэхдээ тус дарааллыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан гэх боловч тус тушаал албан ёсоор ил болоогүй.
- 2021.04.05-ны өдөр төрийн байгууллагаас мэдээлэл хүсэхэд хуульд заасан үндэслэлээр бус албаны даргын нэр буруу бичигдсэн гэж хүсэлтийг буцаасан.

- 2021.04.07-ны өдөр Хятадын вакцины сөрөг нөлөөний талаар албаны мэдээлэл авахаар Эрүүл мэндийн яаманд удаа дараа хандсан иргэнд мэдээлэл өгөөгүй.
- 2021.04.14-ний өдөр Баянзүрх дүүргийн онцгой комисс фейсбүүк дэх албан ёсны цахим хуудсаараа дамжуулж “Хөл хориог чангаруулж явган хүний хөдөлгөөнийг хязгаарлахаар боллоо”. Ингэхдээ “Хатуу хөл хорионы өдрүүдэд автомашин болон явган хүний хөдөлгөөн их байгаа. Тиймээс хөл хориог чангатгаж явган хүний хөдөлгөөнийг хязгаарлахаар болжээ. Тодруулбал явган хүний хөдөлгөөнийг 06:00-08:00, өдрийн 16:00-18:00 цагуудаас бусад цагт бүрэн хязгаарлах аж” гэх мэдээллийг оруулсан. Дараа нь дээрх мэдээлэл нь Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссоос гарсан албан ёсны шийдвэр биш бөгөөд албажаагүй, албан ёсны биш шийдвэрийг цацсандаа нийт иргэдээсээ уучлал хүсье гэсэн.
- 2021.04.26-ны өдөр хавдартай иргэд ХӨСҮТ, ХСҮТ-д эмчилгээ болон вакцинаа хийлгэсэн. Гэвч тэд гэр рүүгээ буцах автобусгүй учир 17:00 цагийг хүлээгээд дэлгүүрт болон гадаа суусан. Хүлээж буй иргэдийн ихэнх нь ахмадууд бөгөөд гэр рүүгээ алхаад явах боломжгүй. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд цагийн хязгаарлалтын талаар урьдчилж мэдээлээгүй, автобусны буудал гэх мэт газарт мэдээлэл хүргэх боломжийг ашиглаагүй байна.
- 2021.05.03-ны өдөр ХӨСҮТ-ийн бохирын шугам задарч, ХӨСҮТ 8 цаг усгүй болж, халдвар тархах их эрсдэлтэй байгаа үйл явдлыг сурвалжилсан зураглаачийн камерыг цохиод шууд бичлэгийг нь хамгаалалтын ажилтнууд тасалсан байна.
- 2021.05.06-ны өдөр өлсгөлөн зарлаж буй үйл явдлыг сурвалжлахаар очсон сэтгүүлчдийн биед цагдаа халдаж, тийнхүү мэдээлэл түгээх үйл ажиллагаанд саад учруулсан нь гамшгийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ч хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг хязгаарлаагүй холбогдох дүрэм журмыг зөрчсөн байна.
- 2021.05.07-ны өдөр ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн дарга Б.Баатархүү “Төв талбай руу сэтгүүлчдийг цөөн тоогоор оруулах чиглэл өгсөн” гэж мэдэгдсэн бөгөөд “чиглэл” нэрийн дор хэвлэн нийтлэх, иргэдэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаанд саад учруулсан байна.
- 2021.05.14-ний өдөр Өнөөдөр сонины сэтгүүлч Мягмаржаргалыг бичсэн нийтлэлтэй нь холбогдуулан Дархан Ар Шанд ХХК-наас 21:30 цагт утсаар дарамталж, устгахыг шаардсан. Мөн хамтран ажиллагч байгууллагын төлөөлөл ДБЭХС ТӨХК-аас редакц дээр нь очиж дарамталж, загнасан.
- 2021.05.18-ны өдөр gogo.mn, eguur.mn-д эрх бүхий байгууллагаас

сонгуулийн тухай хуулийг биелүүлээгүй гэж үзэж сануулга өгсөн. Сануулга нь хуулийн шаардлага бичгээр биш амаар байсан. Тус сайтуудын бэлтгэсэн мэдээлэл нь сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө буюу 2021.05.06-ны өдрийн мэдээ, мэдээлэл байв.

- 2021.05.31-ний өдөр вакцины 2 дахь тунгаа хийлгээд 14 хоноогүй гээд Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийг сурвалжлах мандат олгох боломжгүй гэсэн тайлбар хэлсэн.
- 2021.06.01-ний өдөр NTV телевизийн сэтгүүлчийг “төрийн байгууллагын өгсөн мэдээллээр мэдээ бэлтгэх ёстой” гэж цензурдаж өөрсдөө эрэн сурвалжилж мэдээ бэлтгэх боломжийг хязгаарласан.
- 2021.06.01-ний өдөр Ховд аймгийн Ховд таймс сонины сэтгүүлчийг “төрийн байгууллагаас мэдээлэл өгөөгүй байхад мэдээлэл түгээх эрхгүй” гэж цензур тавьжээ. Үүнийг зөвхөн нэг шугамаар мэдээлэл өгнө гэж тайлбарласан байна.
- 2021.06.03-ны өдөр Live.mn сайтын сэтгүүлч Б.Будрагчааг цагдаагийн байгууллагаас ажлын байрнаас нь албадан авч явж мэдүүлэг авсан.
- 2021.07.02-ны өдөр наадмын бэлтгэл хийж байсан 5 бүжигчний ковид-19 шинжилгээний хариу эерэг хариу гарахад дарга нь ирж “битгий задруул” гэж үүрэг өгсөн нь иргэд, олон нийтийн хувьд ковид-19 цар тахлын нөхцөлд наадам тэмдэглэхтэй холбоотой бодит мэдээлэл авах эрхийг зөрчсөн байна.
- 2021.07.07-ны өдөр Харилцаа холбооны зохицуулах хорооноос Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нэр бүхий өргөн нэвтрүүлгийн 9 телевизийн эфир 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн тасарсан шалтгааныг тодруулах, зөрчлийг арилгуулах асуудлыг яаралтай хэлэлцэж шийдвэрлүүлэхээр “Монголын цахилгаан холбоо” ХК болон Монголын телевизүүдийн холбоотой 3 талт уулзалт зохион байгуулсан. Энэ уулзалтаар иргэдийн мэдээлэл авах эрхийг зориуд хөндсөн эсэх, техникийн шалтгаан, зориудын үйлдэл эсэхийг тодорхой дурдаагүй байна.

Мониторингийн гурав дахь үе шат буюу 2021.10.01-2022.03.31-ний хугацаанд мэдэх эрхийг зөрчсөн 19 тохиолдол байна. Эдгээр зөрчлөөс нийтэд хамааралтай асуудлаарх онцлох зөрчлийг авч үзье.

- 2021.12.09-ний өдөр МҮОНТ-ийн “Нээлттэй хором” нэвтрүүлэг “Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө” сэдэвтэй цацагдсан бөгөөд тухайн нэвтрүүлэгт цагдаагийн болон төрийн байгууллагын зүй бус үйл ажиллагааны талаар ил тод, нээлттэй хэлэлцсэнтэй холбоотойгоор тус нэвтрүүлгийг МҮОНТ-ийн фейсбүүк хуудаснаас устгасан байна.

- 2021.12.27-ны өдөр “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль” буюу “Цар тахлын түр хууль”-ийн үйлчлэх хугацааг 3 дахь удаа сунгах эсэх талаарх олон нийтийн хэлэлцүүлэг идэвхтэй өрнөж буй үед МҮОНТ-ийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрт “АН: Цар тахлын хуулийн зарим заалт улсын төсвийг хяналтгүй зарцуулах эрсдэлтэй” гэсэн гарчиг бүхий мэдээг 20 секунд, “Баянгол дүүргийн МАН-ын хорооноос ахмадууддаа хүндэтгэл үзүүллээ” гэсэн гарчиг бүхий мэдээг 60 секунд тус тус нэвтрүүлжээ.
- 2022.01.06-ны өдөр СХД-т байрлах “Тавантолгой түлш” ХХК-ийн шахмал түлшний үйлдвэр шатаж, улсын онц, тусгай объект тул үйлдвэрийг тэр чигт нь цагдаа нар хамгаалалтад авч, хэвлэлийнхнийг нэвтрүүлээгүй байна.
- 2022.01.05-ны өдөр Монцамэ агентлагийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт харьяалуулсан шийдвэр гаргасан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг зөрчжээ.
- 2022.03.03-ны өдөр МҮОНРТ-ээр 21:10 цагаас гарах байсан цуврал баримтат киноны “Бид босогчид байсан” нэртэй дугаарыг Гүйцэтгэх удирдлага, удирдлагын багийн зүгээс цензурдаж гаргахгүй гэсэн байна.
- 2022.03.17-ны өдөр Улсын төсвөөр барилга барихаар төсвийн мөнгө авсан ч ажлаа хийдэггүй компаниуд, түүний эзэд нь УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатарын хамаарал бүхий хүмүүс байгаа талаар УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатараас тодруулахад “Бүгд гүтгэлэг, би Цахиур.мн-ыг шүүхэд өгөх гэж байгаа” гээд сэтгүүлч С.Будрагчаагийн биед нь халдаж чимхсэн байна.

2.3. Тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчсөн байдал

Мониторингийн эхний үе шат буюу 2020.01.27-2021.02.25-ны хугацаанд тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарласан зөрчлийг агуулгаар нь багцалбал дор дурдсан тохиолдол багтаж байна:

- Иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдэж, тайвнаар жагсаал, цуглаан зохион байгуулсан тохиолдолд хязгаарлалт тогтоож, жагсагчдыг баривчилсан.
- МҮОНРТ-ийн Хамт олны зөвлөлөөс зохион байгуулсан тус телевизийн Захирлын томилгоотой холбоотой Үндэсний зөвлөлийн шийдвэрийг эсэргүүцсэн жагсаалыг тодорхой үндэслэл, хуулийн тайлбаргүйгээр хязгаарласан сэтгүүлч Б.Пүрэвийг албадан авч явж, мэдүүлэг авсан.

Мониторингийн хоёр дахь үе шат буюу 2021.02.25-2021.09.30-ны хугацаанд

тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчсөн 33 тохиолдол байна. Эдгээр зөрчлөөс нийтэд хамааралтай асуудлаарх онцлох зөрчлийг авч үзье.

- 2021.04.15-ны өдөр Үндсэн хуулийн Цэцийн гишүүн Д.Одбаярыг иргэд огцруулах шаардлага хүргүүлэх гэсэн боловч Цэцийн байрыг цагдаа нар хамгаалалтад авч, иргэдийг тараав.
- 2021.04.09-ний өдөр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд хөл хориог эсэргүүцэж, суулт хийхэд цагдаагаас тараасан.
- 2021.03.04-ний өдөр дуучин Т.Ариунаа, түүний гэр бүл хэлмэгдэгсдийн хөшөөний урд суулт зарласныг цагдаагийн байгууллагаас хуулийн дагуу 2 цагийн хугацаанд тарахыг шаардсан. Улмаар Зөрчлийн тухай хуулиар Чингэлтэй дүүргийн эрх бүхий албан хаагч шийтгэл оногдуулсан.
- 2021.04.24-ний өдөр хөл хориог сунгах шийдвэр гарсантай холбогдуулан төв талбайд тайван жагсаал зохион байгуулсан 6 залууг цагдаа нар баривчлан авч явж, жагсаалыг зогсоосон. Үүнийгээ ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн дарга "хөл хориотой үед 5-аас дээш хүн цуглах хориотой, 8 залуугаас мэдүүлэг авч, дараа нь бүгдийг нь сулласан гэж" тайлбарласан.
- 2021.04.24-ний өдөр "Сонгуулиа болиод эхлээд ковид-19 өвчнөө дарахыг давлaгaалъя. НДШ-ийг нэмэхийг эсэргүүцэж байна!", "Ковид-19 өвчинд зарцуулсан мөнгөний тайланг шаардаж байна!!! Хөл хорио ба зээлийн хүү" гэж бичиг барьж гэр хороолол дахь замын хажууд ганцаараа зогссон залууг 5 цаг саатуулсан.
- 2021.05.05-ны өдөр "УИХ-ын гишүүдийн өлсгөлөнг шаардлагатай бол таслан зогсооно" гэж цагдаагийн эрх бүхий албан тушаалтан мэдэгдсэн, дэвсгэр эсгийг нь булаан авсан зэргээр өлсгөлөн хийж үзэл бодлоо илэрхийлж буй шаардлагын агуулга нь эрх баригчдын эсрэг байгаа тохиолдолд цагдаагийн байгууллага тухайн үйлдлийг зогсоох гэж оролдсон байна.
- 2021.06.28-ны өдөр Комедиан Д.Амартүвшиний Сүхбаатарын талбайд "Тэвчээр тасарлаа" уриатай Флаш моб зохион байгуулсантай холбогдуулан Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсээс Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйл буюу Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчсөн үндэслэлээр 500,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.
- 2021.06.27-ны өдөр Сүхбаатарын талбай дээр ковидын улмаас нас барсан иргэдэд эмгэнэл илэрхийлж, зул өргөхийг цагдаагийн байгууллагаас таслан зогсоосон.
- 2021.09.29-ний өдөр Сүхбаатарын талбай дээр үзэл бодлын чөлөөт илэрхийлэл болгож ашигласан хиймэл үхдэлүүдийг хурааж, жагсаал, цуглаан хийж буй иргэдийг цагдаа нар албадан тараасан байна.

Мониторингийн гурав дахь үе шат буюу 2021.10.01-2022.03.31-ний хугацаанд тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчсөн 33 тохиолдол байна. Эдгээр зөрчлөөс нийтэд хамааралтай асуудлаарх онцлох зөрчлийг авч үзье.

- 2021.10.06-ны өдөр ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатарыг огцруулахаар жагссан иргэдийг хүч хэрэглэж, албадан саатуулж, тараах оролдлого эрх бүхий албан тушаалтнууд гаргасан.
- 2021.10.13-ны өдөр Цогтцэций-Чойр чиглэлийн улсын чанартай авто замаар нүүрс тээвэрлэлт явуулахгүй гэсэн Зам тээврийн сайд Л.Халтарын шийдвэрийг эсэргүүцсэн тээврийн жолооч нар Сүхбаатарын талбайд тээврийн машинтайгаа орж ирж, нөхцөл байдлын талаар мэдээлэл хийснийг цагдаагийн алба хаагчид хүч хэрэглэн автомашиных нь хамтаар талбайгаас гаргасан. Тээвэрчдийн зөвлөлийн тэргүүн Н.Ялагдашгүйг цагдаагийнхан баривчлан авч явсан.
- 2021.10.26-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар өөрийн цахим хуудсандаа Хууль зүйн яамны гадаа жагсаал, цуглаан зохион байгуулсан иргэдийг МУЗГ, Монгол Улсын иргэдийн эрх ашгийн эсрэг үйлдэл болсон тухай мэдэгдсэн.
- 2021.11.11-ний өдөр цалингаа нэмүүлэхээр суулт хийсэн эмч нарыг Тагнуулын ерөнхий газраас шалгаж байна.
- 2022.02.09-ний өдөр ХЗДХЯ-ны гадаа 2021.10.06-ны өдөр нэр бүхий иргэд жагсаал, цуглаан зохион байгуулсанд иргэн Д.Отгонтуяаг Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйл “Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн” гэж буруутгаж, улмаар Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс зорчих эрхийг 6 сараар хязгаарлах ял оногдуулж шийдвэрлэсэн.
- 2022.03.31-ний өдөр ОХУ-ын Элчин сайдын яамны гадна жагссан иргэдээс мэдүүлэг авч, гэмт хэрэг зөрчлийн шинжтэй эсэхийг эрх бүхий байгууллагаас шалгасан.

3. Дүгнэлт

Монгол Улсад иргэний болон улс төрийн эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт болон бусад холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулсан. Мониторингийн дүнгээс харахад иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдэх эрх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийг зөрчих явдал тогтмол гарч байна.

Тухайлбал цахим орчинд өөрийн үзэл бодлоо илэрхийлж төрийн үйлчилгээг шүүмжилсэн иргэдийг торгох, саатуулах, сануулах арга хэмжээ авсан тохиолдол, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын мэдээлэл авах, түгээх, хэвлэн нийтлэх эрхийг зөрчих, цензурдэх, хязгаарлах тохиолдлууд их гарав. Орон нутгийн удирдлагын зүгээс хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, дарамт, шахалт үзүүлэх, сүрдүүлэх, мэдээлэл авах эрхийг нь зөрчих тохиолдол газар авсан дүр зураг илрэв. Түүнчлэн иргэдийн эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхэд халдаж, ялгавартай хандах зэрэг асуудал гарсаар байна. Өөрөөр хэлбэл эрх баригчдын эсрэг дуугарсан жагсаал цуглааныг хориглох боловч зарим төрлийн жагсаал, цуглаан, суултад давуу боломж олгох байдал ажиглагдав.

Иймд төрийн байгууллагын алба хаагчдын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээлэл хайх, олж авах, түгээх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийн талаарх хууль, эрх зүйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн байгууллага хоорондын болон төрөөс иргэдэд чиглэсэн мэдээлэл солилцох уялдаа холбоог сайжруулах нэн шаардлагатай байна. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, менежер, ажилтнуудын болон иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх механизмыг сайжруулах нь тулгамдсан асуудал болж байна. Зарим тохиолдолд иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байдлаас эрх нь зөрчигдөж буйг мэдэхгүй, мэдсэн ч дасал болох хандлагатай байна.

4. Зөвлөмж

- Төрийн байгууллагын албан тушаалтнууд цар тахлын үед гаргах аливаа шийдвэр, үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт болон бусад холбогдох хууль тогтоомжоор баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээлэл хайх, олж авах, түгээх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийг зөвхөн хууль зүйн хангалттай үндэслэл, бодит шаардлага, тохирох арга хэмжээнээс бусад үед хязгаарлахгүй байх. Тийнхүү хязгаарлах тохиолдолд хамгийн бага хязгаарлахад онцгой анхаарах. Үүний тулд эдгээр эрхийг зөрчихөөс сэргийлэх боломжит бүхий л арга хэмжээ авах, тийнхүү арга хэмжээ авсан гэдгээ нотлох.
- Төрийн байгууллагын албан тушаалтнууд цар тахлын үед гаргах аливаа шийдвэр, хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа урьдчилан хүний эрхийг зайлшгүй хязгаарлах шаардлагатай эсэх талаар хөндлөнгийн буюу мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулж байх.
- Төрийн байгууллагын албан тушаалтнууд цар тахлын үед гаргах аливаа шийдвэр, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа урьдчилан иргэд, олон нийтэд болон тэдгээр шийдвэрийг газар дээр хэрэгжүүлэх бусад албан хаагчдад боломжит хугацаанд танилцуулж, төрийн байгууллагын албан тушаалтнууд болон иргэдийн хооронд нэгдмэл ойлголт бий болгох.
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээлэл хайх, олж авах, түгээх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийг үндэслэлгүйгээр буюу бодит бус шаардлагаар хязгаарласан аливаа эрх зүйн акт, шийдвэрийг даруй хүчингүй болгох буюу өөрчлөх.
- Энэ хүрээнд Хууль тогтоогч буюу Улсын Их Хурлын хувьд Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль дахь “худал мэдээлэл”, “илт худал мэдээлэл” гэх зохицуулалт “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй”, “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэсэн зарчимтай шууд харшилж байгааг хүлээн зөвшөөрч, Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1-т заасан “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээх”, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1-т заасан “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараах” гэмт хэргийг тус тус хуулиас хасах.
- Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2020 оны А/200, А/169 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд

зохицуулалт хийх журам"-д заасан эрх бүхий байгууллагын дүгнэлт, саналд хөндлөнгийн этгээд буюу шинжээчийн дүгнэлт гаргуулж байх талаар өөрчлөлт оруулах. Энэ хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрх журмуудын дагуу шийдвэрлэж буй гомдлын агуулга, шийдвэрийн талаар тухай бүр цахим хуудсаараа дамжуулан ил тод мэдээлж байх.

- Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар гомдол гаргасан тохиолдолд түүнийг шалгаж, шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс тухайн нийтлэл, мэдээлэлд дурдсан агуулгатай холбоотой урьдчилж бэлтгэсэн бодит, бүрэн мэдээлэл байсан эсэх, тийнхүү мэдээлэл байхад зориуд тухайн нийтлэл, мэдээллийг нийтэлсэн эсэхийг заавал харгалздаг байх.
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээлэл хайх, олж авах, түгээх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийг хангалтгүй үндэслэлээр, бодит бус шаардлагаар, тохиромжгүй арга хэрэгслээр хязгаарлаж буй эсэхэд байнгын дотоод болон хөндлөнгийн хяналт тавих, тэрхүү хяналтаар тогтоогдсон зөрчлийг даруй зогсоож хэвших.

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ?

Мониторингийн хугацаанд гарсан зарим кейсд тулгуурлан хүний эрхийн зөрчил мөн эсэхэд дүгнэлт хийх зорилгоор хуульчийн тайлбар бэлтгэж цахим сүлжээгээр түгээснийг доорхоос үзнэ үү.


Хуульчийн тайлбар-1



ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ?

ЮУ БОЛОВ?

Гэрийн тусгаарлалтад байгаа иргэдийн хаалга болон хашааны гадна талд "КОВИД-19"-ын тусгаарлалтад байгааг илтгэсэн хуудас наав.



Хуульчийн тайлбар

Энэхүү үйлдэл нь Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйл "Хүнийг үндэс, угсаа, хэл, нас, хүйс ...эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж..." нөхцөлд хамаарна. Хариуцлагын тухайд ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол 450 нэгжээс 5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй бөгөөд 1-5 жилийн хугацаагаар хорих ял шийтгэлтэй.

Ялгаварлан гадуурхалтын эсрэг Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-тэй холбоотой хэрэг маргааныг шүүхээс шийдвэрлэж байгаа байдал маш хангалтгүй байгаа. Тодруулбал, 14.1.1-ээр 2018-2020 онд 4 хэрэг анхан шатны шүүхээр, давж заалдах шатны шүүхээр 2017-2020 онд 4, тус тус шийдэгдсэн бөгөөд хүндрүүлэх нөхцөл болох хүч хэрэглэж, бүлэглэн, албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэнтэй нь холбогдуулан 14.1.2-аар шийдвэрлэгдсэн хэрэг гурван шатны шүүхэд байхгүй байна. Эдгээр шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг уншвал шүүхээс "ялгаварлан гадуурхсан" гэдэг зүйл ангиар шийтгэвэр оногдуулахдаа ялгаварлан гадуурхалт мөн байсан эсэхийг тогтоохгүйгээр иргэдийн хоорондын маргаанаас гэмтэл учирсан асуудлыг ч 14.1-д хамаатуулан шийдвэрлэсэн байхыг харж болно.

Одоогоор ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулийн төсөл олон нийтээр хэлэлцүүлж буй бөгөөд УИХ-д өргөн барьсан тухай мэдээлэл ХЗДХЯ-ны цахим хуудаст байхгүй байна.

Глоб Интернэшнл төвийн хуульч, Б.Пүрэвсүрэн



Хүний эрхийн зөрчил мөн үү?

Юу болов?

Сүхбаатар дүүргийн ЗДТГ-аас 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн ЗДТГ болон 1-20 дугаар хорооны Ажлын алба, Иргэдэд үйлчлэх Төр захиргааны төв байранд үйл ажиллагаа эрхэлж буй хэлтэс, нэгжээс төрийн үйлчилгээ авахаар ирж буй иргэдийг коронавирус илрүүлэх PCR шинжилгээнд заавал хамрагдсан байхыг мэдэгдэв.



МЭДЭГДЭЛ

Монгол улсын Засгийн газраас нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд мордож буй "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг"-ийг 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн оглооний 06:00 цаг хүртэл сунгах шийдвэр гарсан.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд коронавируст /КОВИД-19/ тархалт буурахгүй байгаатай холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахихаар хариу арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Иргэдэд үйлчлэх Төр захиргааны төв байранд үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, хэлтэс, нэгжүүдийн ажилтан, албан хаагчид коронавирус илрүүлэх /PCR/ шинжилгээнд заавал хамрагдсан байх бөгөөд үйлчлүүлж буй иргэдэд энэ шаардлагыг тавьж ажиллахыг мэргэжлийн байгууллагаас чиглэл болгосон.

Иймд 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дүүргийн ЗДТГ болон 1-20 дугаар хорооны Ажлын алба, Иргэдэд үйлчлэх Төр захиргааны төв байранд үйл ажиллагаа эрхэлж буй хэлтэс, нэгжээс төрийн үйлчилгээ авахаар ирж буй иргэн ТА коронавирус илрүүлэх /PCR/ шинжилгээнд заавал хамрагдсан байхыг мэдэгдэж байна.

Халдвар, хамгааллын дэглэмийг сайтар мордож, хайртай хүмүүсээ хамгаалъя.

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Хуульчийн тайлбар

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаа дууссан үед Сүхбаатар дүүргийн төрийн захиргааны байгууллагаас иргэн үйлчилгээ авахын тулд заавал шинжилгээ өгсөн байх нэмэлт шаардлага тавьж байгаа нь буруу. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед иргэн төрөөс үйлчилгээ авахаар ирэхэд Гамшигаас хамгаалах тухай хуулийн 37.2.8-д зааснаар иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичгээс өөр зүйл шаардаж болохгүй. Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын мэдэгдэлд түүний хууль зүйн үндэслэлийг заагаагүй, иргэд шинжилгээ өгөх газар, цагийн талаар тодорхой мэдээлэл тусгаагүй нь буруу байна. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т зааснаар хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны зарчим тул цар тахлын үеэрх аливаа төрийн байгууллага, албан тушаалтан зөвхөн хуульд үндэслэн шийдвэр гаргахыг шаардах эрхтэй.

Хуульч, судлаач Л.Галбаатар




Eguur.mn

"Тусгаарлагдсан иргэд дундаа групп чат нээтэл "Битгий элдэв юм бичээд бай" гээд цаанаас хаачихсан"



Б. Буяндалай • 3 долоо хоног



ЮУ БОЛОВ?

Тусгаарлагдсан иргэд санал бодлоо солилцох, мэдээллээ хуваалцах зорилгоор нэгдэн фэйсбүүкт групп чат үүсгэтэл групп чатыг хаасан тохиолдол гарав.

-Групп чат үүсгээд, тэндээ юу гэж бичих, яах нь хувь хүний эрх шүү дээ, уг нь.

-Уг нь тийм шүү дээ. Бид өөрсдийгөө хүнлэг, энэрэнгүй Ардчилсан Монгол Улсын иргэн гэж боддог. Гэтэл бодит байдал ийм байна. Групп чатанд бидний бичсэн зүйл гадагшаа задралд байсанд гайхсан. Бид цахим орчинд элдэв юм бичээгүй. Гэтэл групп чатанд ганц, нэг шүүмжлэл хэлсэн хүний өрөөний үүдийг нь цохиод "Битгий элдэв юм бичиж, бусдыгаа турхираад бай" гэж сануулсан нь үнэхээр аймар, би их цочирдсон. Бид 14 хоногийн хугацаанд УОК-ын шийдвэрийг хүндэтгээд нэг ч удаа элдэв юм яриагүй. Тийм байхад ийм тодорхойгүй, тоталитар байдлаас



Хүний эрхийн зөрчил мөн үү?

Хуульчийн тайлбар

МУҮХ-иар иргэн бүр итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх... эрх чөлөөтэй. /16 дугаар зүйлийн 16.16/ Түүнчлэн МУҮХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэж заасан.

2011 онд хуралдсан НҮБ-ын Хүний эрхийн хорооны 102-р чуулганаар батлагдсан ИБҮТЭОУП-ын 19-р зүйлийн 34 дүгээр нэмэлт тайлбарт "Интернэт, гар утас зэрэг мэдээлэл түгээх электрон системд тулгуурласан мэдээлэл, мэдээлэл харилцааны хөгжил нь дэлхийн хэмжээнд мэдээлэл харилцааны практикт үлэмж өөрчлөлт хийснийг Гишүүн улсууд анхаарч үзвэл зохино. УИХ-аас 2020.04.29-ний өдөр баталсан "Коронавируст халдвар Ковид-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуульд Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд 11.1.1.хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх; 11.1.2.үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх; 11.1.3.энэ хуулийн 11.1.2-т заасан зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байх гэсэн гурван шалгуурыг хангасан байхаар зохицуулсан. Гэвч эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэргүйгээр иргэдийн цахим хуудас, групп чатыг хааж, хязгаарлах асуудлыг холбогдох хуулиар зөвшөөрөөгүй байна.

Иймд аливаа асуудлаар иргэд цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, эвлэлдэн нэгдсэн тохиолдолд хязгаарлах, хаах эрх зүйн үндэслэл тогтоогдохгүй байна.

Глоб Интернэшнл төвийн хуульч, Б.Пүрэвсүрэн



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ГЛОБ
ИНТЕРНЭШНЛ
ТӨВ

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ?

ЮУ БОЛОВ?



Нармандах Сугар

April 26 at 9:48 AM · 3



Хэвлэлийн логотой машинуудыг цагийн хязгааргүй явуулахаар боллоо гэж ЗГ мэдэгдсэн. Гэтэл цагдаа нар нь явуулахгүй байна. 13-р зууны тушаал шийдвэрүүдээс ч удаан хэрэгжих юм. Нэг бол онц байдлаа зарлаад хэвлэлүүдээ хаачаач дээ яршиг



Galbaatar Lkhagvasuren and 58 others

9 Comments 9 Shares

ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

ЗАСГИЙН ГАЗРААС 2021.04.08-НЫ ӨДӨР КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ЭРЧИМЖҮҮЛЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДРИЙН 06:00 ЦАГААС 5 ДУГААР САРЫН 8-НЫ ӨДРИЙН 06:00 ЦАГ ХҮРТЭЛХ ХУГАЦААНД ГАМШГААС ХАМГААЛАХ БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН.

МӨН ЗАСГИЙН ГАЗРААС 2021.04.23-НЫ ӨДӨР ГАМШГААС ХАМГААЛАХ БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААГ 2021 ОНЫ 5 ДУГААР САРЫН 8-НЫ ӨДРИЙН 06:00 ЦАГ ХҮРТЭЛ СУНГАСАН.

ҮҮНТЭЙ ХОЛБООТОЙГООР УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА 2021.04.05-НЫ ӨДӨР "ТҮР ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ" 37 ДУГААР ТУШААЛ ГАРГАЖЭЭ. ЭНЭХҮҮ ТУШААЛЫН ХАВСРАЛТААР БАТАЛСАН "БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААНД НИЙСЛЭЛ ХОТОД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ"-ЫН 4.1-Т "...ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХЯЗГААРЛАЛТ ТОГТООГООГҮЙ ЧИГЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ӨМНӨ НЬ ОЛГОЖ БАЙСАН ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮСЭЛТ ШААРДАХГҮЙГЭЭР СЭРГЭЭН ОЛГОХ ЭСЭХИЙГ АЖЛЫН ХЭСЭГ ШИЙДВЭРЛЭНЭ" ГЭЖЭЭ.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГА, СЭТГҮҮЛЧДИЙН ХУВЬД "ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХЯЗГААРЛАЛТ ТОГТООГООГҮЙ ЧИГЛЭЛ"-Д ХАМААРЧ БАЙГАА ТУЛ ДЭЭРХ ЖУРМЫН ДАГУУ QR КОД АВЧ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ШААРДЛАГАТАЙ БОЛСОН.

ГЭТЭЛ ДЭЭР ДУРДСАН ЖУРАМД ЦАГИЙН ХЯЗГААРЛАЛТЫН ТАЛААР ОГТ ДУРДААГҮЙ БАЙХАД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Х.НЯМБААТАР 2021.04.25-НЫ ӨДӨР "ЭНЭ УДААГИЙН КОД ОЛГОЛТ ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ. ЗӨВХӨН 07:00-09:00, 17:00-20:00 ЦАГУУДАД ЗОРЧИНО" ГЭЖ МЭДЭГДСЭН. МӨН НТВ ТВ-ИЙН СЭТГҮҮЛЧ Н.СУГАРЫН МЭДЭЭЛСНЭЭР, "ХЭВЛЭЛИЙН ЛОГОТОЙ МАШИНУУДЫГ ЦАГИЙН ХЯЗГААРГҮЙ ЯВУУЛАХААР БОЛЛОО ГЭЖ ЗАСГИЙН ГАЗРААС МЭДЭГДСЭН. ГЭТЭЛ ЦАГДАА НАР НЬ ЯВУУЛАХГҮЙ БАЙНА".

ЦЕГ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.БААТАРХҮҮ 2021.04.26-НЫ ӨДРИЙН МЭДЭЭЛЭЛДЭЭ "...СЭТГҮҮЛЧДИЙН ХУВЬД ӨГЛӨӨ 10:00 ЦАГ ХҮРТЭЛ ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭРЭЭ ЗОРЧООД, ӨДРИЙН ЦАГААР БАЙГУУЛЛАГЫНХАА ПОГО БҮХИЙ QR КОДТОЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ АЖЛАА ЗОХИЦУУЛНА. ИНГЭХДЭЭ ТУХАЙН СЭТГҮҮЛЧ НЬ ӨӨРИЙНХӨӨ БИЧИГ БАРИМТТАЙ ЯВНА. ... ЖУРАМТАЙ ХОЛБООТОЙ ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙГ ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДАД ХҮРГЭЖ БАЙГАА. НЭМЭЛТЭЭР АЖИЛЛАЖ БАЙГАА АЛБА ХААГЧДАД АРАЙ ХҮРЭЭГҮЙ БАЙХЫГ ҮГҮЙСГЭХГҮЙ. АЛЬ БОЛОХ ХҮРДАН ХҮРГЭЖ АЖИЛЛАЖ БАЙНА." ГЭЖ МЭДЭГДСЭНЭЭС ХАРАХАД ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИД БҮРЭН МЭДЭЭЛЭЛГҮЙ, УЛМААР ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЯЗГААРЛАЖ БАЙГАА НЬ ТОДОРХОЙ БОЛЛОО.

ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТЫН 19 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН ТАЛААР НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХОРООНЫ 102-Р ЧУУЛГАНААР БАТАЛСАН ТАЙЛБАРЫН 45-Д "... СЭТГҮҮЛЧ, ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧЛИЙГ МӨРДӨГЧДӨД ТУХАЙН ГИШҮҮН УЛС ДОТРОО (ЗӨРЧИЛД НЭРВЭГДСЭН ГАЗАР НУТАГ, БАЙГАЛИЙН ГАМШИГ ГАРСАН, ХҮНИЙ ЭРХИЙГ ГУТААН ДОРОМЖИЛСОН ГЭХ МЭТ ГАЗАР) ХӨДЛӨН ЯВАХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ НЬ ПАКТЫН 19 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 3 ДАХЬ ХЭСЭГТ ЕРӨНХИЙДӨӨ ҮЛ НИЙЦНЭ." ГЭСНИЙГ ДЭЭРХ ЖУРМЫН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ ХАНГАХГҮЙ БАЙНА.

НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИССАРЫН ГАЗРААС 2020.05.13-НЫ ӨДӨР ГАРГАСАН "КОВИД-19 УДИРДАМЖ"-Д ЗААСНААР КОВИД-19-ТЭЙ ХОЛБООТОЙГООР ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЭРХ ХЭМЖЭЭГЭЭ ГАГЦХҮҮ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЗОРИЛГООР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭС БҮС ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД ЭСВЭЛ СЭТГҮҮЛЧДИЙН АЖИЛ, ҮЙЛ ХЭРГИЙГ НЯЦААХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЭСВЭЛ ТЭДНИЙГ ЧИМЭЭГҮЙ БОЛГОХОД АШИГЛАХ ЁСГҮЙ ЮМ.

ИЙМД ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ЗҮГЭЭС QR КОД ОЛГОХ НЭРИЙН ДОР СЭТГҮҮЛЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗҮЙ БУСААР ХЯЗГААРЛАХ ҮЙЛДЛЭЭ ДАРУЙ ЗОГСООХЫГ ШААРДАЖ БАЙНА.

Хуульч, судлаач Л.Галбаатар



Нээлттэй
Нийгэм
Форум



ГЛОБ
ИНТЕРНЭШНЛ
ТӨВ

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ?

ЮУ БОЛОВ?

Монгол Улсын Консерваторийн багш, ажилчид "Сургуулийн газраа аврах түр хороо" байгуулан жагсаал цуглаан зохион байгуулсантай холбогдуулан ковидын нөхцөл байдал хийгээд хөл хорионы түвшин улбар шар зэрэглэлд байхад жагсаал цуглаан зохион байгуулсан хэмээн Ерөнхий зохицуулагч Монгол Улсын гавьяат багш, Консерваторийн УЗ-ийн гишүүн Б.Зоригтыг 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдөр 150000 төгрөгөөр торгов.



Хуульчийн тайлбар

Монгол Улсын Консерваторийн багш нарын жагсаалыг зохион байгуулагчийг Зөрчлийн тухай хуулиар 150 мянган төгрөгөөр торгосон нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй явдал юм. Тодруулбал, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д зааснаар Монгол Улсын иргэн тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.

Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно, 3-т зааснаар хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй. Гэтэл онц болон дайны байдал зарлаагүй үед, хууль бус үйл ажиллагааг эсэргүүцэж халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн жагсаал зохион байгуулсан иргэнийг торгож байгаа нь Үндсэн хуулиар баталгаажуулсан эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарлаж байгаа хэрэг.

Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 1-т "хуулиар хориглосон газарт, эрх бүхий байгууллагад бүртгүүлэлгүйгээр, эсхүл мэдэгдэл хүргүүлснээс хойш хуульд заасан хугацаа өнгөрөөгүй байхад жагсаал, цуглаан зохион байгуулсан, эсхүл жагсаал, цуглааны явцад түүний зорилгыг өөрчилж хориглосон жагсаал, цуглаан зохион байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан нь ердийн хуулиар буюу Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар Үндсэн хуульд баталгаажуулсан эрх, эрх чөлөөг зүй бусаар хөндөж байна. Дээрх заалт нь бүхэлдээ жагсаал, цуглаан хийх эрхийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээс хамааралтай болгож хүний эрхийг зүй бусаар хязгаарласан шинжтэй байна.

Үндсэн хуулийн 70 дугаар зүйлийн 1-т зааснаар Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино. Иймд жагсаал, цуглаан хийх эрхийг зүй бусаар хөндөж, Зөрчлийн хуулиар торгосон шийдвэрийг шүүхэд давж заалдах нь зүйтэй бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6.4-т зааснаар шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй, эсхүл харшилсан гэж үзвэл тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, тухайн хуулийн талаарх саналаа Улсын дээд шүүхэд гаргах зохицуулалтыг баримтлах шаардлагатай юм. Энэ зохицуулалт нь Үндсэн хуульд нийцээгүй хууль тогтоомжоор хүний эрхийг хязгаарлаж болохгүй байх баталгаа юм.

Хуульч, судлаач Л.Галбаатар



ЮУ БОЛОВ?

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэтэй Бага тэнгэрийн аман дахь гэрийнх нь гадаа уулзахаар очсон ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг цагдаа нар саатуулсан байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ?

Энэ нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-т “цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалалтад байгаа газар”-т жагсаал, цуглаан хийхийг хориглоно гэж заасантай холбоотой байх хэдий ч тус хуулийн 14 дүгээр зүйлийн 2, 3-т зааснаар Засаг дарга бичгээр дээрх жагсаал, цуглааныг тараахыг шаардах, тийнхүү шаардсаны дараа тараагүй бол жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллага хуульд заасан арга, хэрэгслээр албадан тараана. Хуулийн энэ зохицуулалтыг баримтлахгүйгээр иргэдийг саатуулсан нь Үндсэн хуульд заасан жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчсөн байна.

Хуульч, судлаач Л.Галбаатар



ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ ?



ЮУ БОЛОВ?

Шүүхийн хэвлэл мэдээллийн ажилтнуудаас эрхлэн хүргэдэг "Шүүхийн мэдээ" фэйсбүүкийн хуудаст 2021.11.18-ны өдөр Д.Амартүвшин, Д.Булгантамир нарт холбогдох зөрчлийн хэргийн талаар мэдээлжээ.

Энэ мэдээлэлд дурдсанаар цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагчаас Д.Амартүвшин, Д.Булгантамар нарт Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...Эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн..." мөн хуулийн 5.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "...Эрх бүхий байгууллагад бүртгүүлэхгүйгээр жагсаал цуглаан зохион байгуулсан..."

зөрчилд тус тус оногдуулсан шийтгэл үндэслэлтэй эсэхийг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянажээ.

Ингэхдээ 2021.06.28-ны өдөр "...Флаш моб" нэртэй цуглааныг бүртгэлгүйгээр зохион байгуулж, хорио цээрийн дэглэм, хягаарлалт тогтоосон Нийслэлийн засаг даргын 2021.06.16-ны өдрийн А/477 дугартай захирамжийг зөрчсөн нь үндэслэлтэй байна гэж үзэж зөрчилд холбогдогч Д.Амартүвшин, Д.Булгантамир нарыг Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 500.000 төгрөгөөр тус тус торгох шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн байна.



Нээлттэй
Нийгэм
Форум



ГЛОБ
ИНТЕРНЭШНЛ
ТӨВ



ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2-т заасан "Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн" гэх нөхцөлийг хэрэглэхийн тулд Нийслэлийн засаг даргын 2021.06.16-ны өдрийн А/477 дугаартай захирамжаар "хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм" тогтоосон эсэхийг тогтоох ёстой. Гэвч энэхүү "Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай" тухай захирамжид ямар нэгэн "хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм" тогтоосон талаар, тэрхүү хязгаарлалт, дэглэм ямар хугацаанд үйлчлэх талаар заалт байхгүй.

Гамшигаас хамгаалах тухай хуулийн 4.1.23-т "хязгаарлалтын дэглэм" гэж засаг захиргаа, нутаг дэвсгэр, голомтын бүсэд гамшигаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох, иргэн, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон эрхийг хязгаарлахыг хэлнэ гэж заасан. Дээрх захирамжид Гамшигаас хамгаалах хуулийг огт баримтлаагүй бөгөөд дээрх 4.1.23-т заасан дэглэмд хамаарах нөхцөлийг заагаагүй.

Мөн хуулийн 10.4.4-т зааснаар гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед "хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох" бөгөөд 11.3.3-т зааснаар улсын хэмжээнд, эсхүл нийслэлийн нутаг дэвсгэрт Улсын Онцгой комиссын даргын саналыг үндэслэн Засгийн газар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргана.

Эндээс харахад Д.Амартүвшин, Д.Булгантамар нарыг Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...Эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн..." гэж буруутгаж, шийтгэсэн нь үндэслэлгүй байна.

Хэдийгээр Засгийн газрын 2021.05.27-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021.06.30-ны өдрийг дуустал сунгасан хэдий ч энэ нь хорио цээр хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм тогтоосон гэсэн үг биш юм. Тодруулбал, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10.7-т зааснаар бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед энэ хуулийн 10.4-т заасан арга хэмжээг бүхэлд нь хэрэгжүүлэх бөгөөд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед дээрх арга хэмжээг бүхэлд нь хэрэгжүүлэхгүй.

Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 1-т зааснаар эрх бүхий байгууллагад бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 150 мянган төгрөгөөр торгоно. "Шүүхийн мэдээ"-нд дурдсанаар Д.Амартүвшин, Д.Булгантамар нарыг 500 мянган төгрөгөөр торгосон гэж мэдээлсэн байх бөгөөд 150 мянган төгрөгөөр торгосон талаар дурдаагүй байна. Эндээс харахад, цагдаагийн албан хаагчаас дээрх нэр бүхий иргэдийг Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "...Эрх бүхий байгууллагад бүртгүүлэхгүйгээр жагсаал цуглаан зохион байгуулсан..." зөрчилд буруутгасан нь үндэслэлгүй гэж шүүхээс шийдвэрлэсэн байна.

Цаашид цагдаагийн албан хаагч болон шүүхээс хөдөлгөөний хязгаарлалт нэрийн дор Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д заасан тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчихгүй байхад анхаарах хэрэгтэй байна.

ХУУЛЬЧ, Л.ГАЛБААТАР



ЮУ БОЛОВ?

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗИЙН “НЭЭЛТТЭЙ ХОРОМ” НЭВТРҮҮЛЭГ “ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ” СЭДЭВТЭЙ ЦАЦАГДСАН БӨГӨӨД ТУХАЙН НЭВТРҮҮЛЭГТ ЦАГДААГИЙН БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗҮЙ БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ ХОЛБООТОЙГООР УГ НЭВТРҮҮЛГИЙГ ТУС ТЕЛЕВИЗИЙН ФЭЙСБҮҮК ХУУДАСНААС УСТГАСАН БАЙНА.

ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

ЭНЭ НЬ 2012 ОНЫ 6 ДУГААР САРД НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ “ХҮМҮҮСИЙН ОФФЛАЙН ОРЧИН ДАХЬ ЭРХҮҮД, ТЭР ДУНДАА ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ОНЛАЙН ОРЧИНД НЭГЭН АДИЛ ХАМГААЛАГДАХ ЁСТОЙ” ГЭЖ ЗААСНЫГ ЗӨРЧИЖ ЦАХИМ ОРЧИНД МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ЗӨРЧСӨН БАЙНА.

ЭНЭ ЯВДАЛ НЬ “ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН 4.1-Т “ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХАРААТ БУС БАЙХ, БОДИТ МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ИРГЭНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ, ОЛОН УРГАЛЧ ҮЗЭЛ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ХУВЬ ХҮН, УЛС ТӨРИЙН НАМЫН ЭРХ АШГИЙГ БУС НИЙТ ҮНДЭСНИЙ ЭРХ АШГИЙГ ДЭЭДЛЭХ ҮНДСЭН ЗАРЧМЫГ БАРИМТАЛНА” ГЭСНИЙГ МӨН ЗӨРЧСӨН БАЙНА.

ХУУЛЬЧ, Л.ГАЛБААТАР



Нээлттэй
Нийгэм
Форум



ГЛОБ
ИНТЕРНЭШНЛ
ТӨВ

ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ?

ЮУ БОЛОВ?

“Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль” буюу “Цар тахлын түр хууль”-ийн үйлчлэх хугацааг 3 дахь удаа сунгах эсэх талаарх олон нийтийн хэлэлцүүлэг идэвхтэй өрнөж буй үед буюу 2021.12.27-ны өдөр Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрт “АН: Цар тахлын хуулийн зарим заалт улсын төсвийг хяналтгүй зарцуулах эрсдэлтэй” гэсэн гарчиг бүхий мэдээг 20 секунд, “Баянгол дүүргийн МАН-ын хорооноос ахмадууддаа хүндэтгэл үзүүлээ” гэсэн гарчиг бүхий мэдээг 60 секунд тус тус нэвтрүүлжээ.

FREEDOM PRESS



ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 4.1-т зааснаар олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа олон ургальч үзлийг эрхэмлэх, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална. Мөн хуулийн 8.2.2-т зааснаар олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургальч үзэл бодлыг хүндэтгэж, тэдгээрийг тэгш илэрхийлэх үүрэгтэй.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн талаарх НҮБ-ын Хүний эрхийн хорооны 34 дүгээр тайлбарт “Гишүүн улсууд нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хараат бус байдлыг хангавал зохино. Үүнтэй холбогдуулан Гишүүн орон түүний хараат бус байдал, редакцийн эрх чөлөөг баталгаажуулах ёстой” гэж заасан.

2021.12.27-ны өдөр МҮОНТ-ийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрт эрх баригч нам болон сөрөг хүчний мэдээллийг хэт тэнцвэргүй буюу эрх баригч намд хэт илүү цаг олгосон нь Олон нийтийн радио, телевизийн тухай хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ буюу Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг ноцтой зөрчсөн явдал юм.

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлөөс түүний редакцийн хараат бус байдлыг хангахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай бөгөөд олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангаж буй эсэхэд иргэд хяналт тавьж байх нь улам чухал болж байна.

Хуульч, судлаач, Л.Галбаатар



Нээлттэй
Нийгэм
Форум



ГЛОБ
ИНТЕРНЭШНЛ
ТӨВ

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ?



ЮУ БОЛОВ?

“БЗД-н эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд улс орныхоо шударга бус байдал, сайд дарга нарын давхар стандарттай байдлыг шүүмжилж ХЗДХЯ-ны гадаа үүдэнд үг үзэл бодлоо илэрхийлсэн иргэн Д.Отгонтуяаг цагдаа нар баривчлахад эсэргүүцэл үзүүлсэн гэх шалтгаанаар буруутгаж хэргийг шүүхэд шилжүүлжээ. түүнийг баривчлахдаа гарыг нь өчиж мушгиснаас гарын шөрмөс нь суналттай, үрэвссэн. /MRI авахуулсан/ Хөхрөлт, зөөлөн эдийн гэмтэлтэй.



ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 44.1-т зааснаар цагдаагийн байгууллага жагсаал, цуглааныг албадан тараахын өмнө оролцогчдод бүх төрлийн холбоо, мэдээллийн хэрэгсэл ашиглан жагсаал, цуглааныг албадан тараах тухай Засаг даргын шийдвэрийг мэдэгдэж, биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн тохиолдолд авах арга хэмжээг урьдчилан анхааруулна. Ингэж мэдэгдсэн эсэх нь тодорхойгүй нөхцөлд иргэнд албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нь буруу юм.

Мөн тус хуулийн 48.1.2-т албадлагын арга хэмжээг нэн тэргүүнд хэрэглэхгүй байх; 48.1.3-т албадлагын арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх үүрэг болгосон.

Цагдаагийн албан хаагч албадлагын арга хэмжээг хэрэглэх үеийн эсэргүүцлийг Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1-т заасан “Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн” гэх гэмт хэргээр буруутгаж болохгүй.

Хуульч, судлаач, Л.Галбаатар



Нээлттэй
Нийгэм
Форум



ЮУ БОЛОВ?

2022 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр "МОНЦАМЭ" агентлагийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт харьяалуулсан шийдвэр гаргав.



Хуульчийн тайлбар

Энэ нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг зөрчжээ. Тухайлбал, тус шийдвэр нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дэх хэсэгт "Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй байна. МОНЦАМЭ агентлаг нь Улсын төсвөөс санхүүждэг боловч ЗГ болон бусад аливаа төрийн институцид албан ёсоор харьяалагдах нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн зөрчил юм. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдсантай холбоотойгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай МУИХ-ын 103 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт "Радио, телевизийн хэрэг эрхлэх газар, МОНЦАМЭ агентлагийг Засгийн газрын тохируулагч агентлагийн хувьд татан буулгаж, Үндэсний нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болгон өөрчлөн зохион байгуулсугай." гэсэн шийдвэр гарснаар өнөөг хүртэл эрх зүйн статус нь тодорхойгүй хэвээр байгаа юм. Хожим буюу 2015 онд УИХ-ын 58 дугаар тогтоолоор 1998 оны 103 дугаар тогтоолын зөвхөн 2 дахь заалт буюу "Хууль, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар болон хуулиар олгогдсон эрх бүхий байгууллагын нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг гагцхүү Төрийн мэдээлэл эмхэтгэлд албан ёсоор хэвлэн нийтэлж байхаар тогтоосугай." гэснийг хүчингүй болгосноос үзвэл, УИХ-ын 1998 оны дээрх 103 дугаар тогтоолын 4 дэх заалт одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилсээр байтал Ерөнхийлөгчийн Тамгын газар нь дэргэдээ МОНЦАМЭ агентлагийг харьяалуулах шийдвэр гаргасан нь холбогдох хууль болон тогтоолыг зөрчсөн үйлдэл байна.

ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВИЙН ХУУЛЬЧ, Б.ПҮРЭВСҮРЭН



ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

ЮУ БОЛОВ?

1

“Угаартаж үхлээ” гэх бичвэртэй хуудас барьж Улсын Их дэлгүүрийн орчим зогссон залууг зөвшөөрөл авалгүй жагссан гээд цагдаагаас дуудаж, авч явсан байна.

2

“Угаартаж үхлээ” гэх бичвэртэй хуудас барьж Улсын Их дэлгүүрийн орчим зогссон залууг зөвшөөрөл авалгүй жагссан гээд цагдаагаас дуудаж, авч явсан байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар нэг иргэний үйлдлийг жагсаал, цуглаанд хамааруулж үзэхгүй.

2. Эрүүгийн хуулийн 14.1 дугаар зүйл Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, эрх чөлөөнд халдах гэмт хэрэгт “Өөрийн эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол...” ял шийтгэхээр зохицуулсан. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйл “Гэрч, хохирогч мөрдөн шалгах ажиллагааны үед шүүхэд үнэн зөв мэдүүлэг өгөхөө илэрхийлж, баталгаа гаргасны дараа зориуд худал мэдүүлэг өгсөн бол...” гэмт хэрэгт тооцож хариуцлага хүлээлгэнэ.

**ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВИЙН
ХУУЛЬЧ, Б.ПҮРЭВСҮРЭН**



ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

ЮУ БОЛОВ?

2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр www.ergelt.mn мэдээллийн сайтын редакцад Эрүүгийн цагдаагийн газраас шалгалт хийж, Ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүдийн гомдлоор нэгжлэг, ажлын байрны зураг авалт хийсэн. Ингэхдээ үзлэг, шалгалтын зөвшөөрөл, бусад бичгийг үзүүлээгүй, үзүүлэх шаардлагагүй гэжээ.

Ийм ажиллагаа нь хууль бус мөрдөн шалгах ажиллагаанд тооцогдоно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүний халдашгүй байх эрхэд хууль ёсны дагуу халдахад баримтлах хэм хэмжээг зохицуулсан. Тодруулбал, 24.1 дүгээр зүйлд нэгжлэг хийх, 24.3 дугаар зүйлд орон байр, бусад газарт нэгжлэг хийх, 24.4 дүгээр зүйлд эд мөрийн баримт хураан авах, 24.5 дугаар зүйлд мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах талаар тус тус зохицуулсан бөгөөд эдгээр ажиллагааг явуулах хангалттай үндэслэл байгаа талаар мөрдөгч санал гаргаж, прокурорын зөвшөөрлийг авна. Ажиллагааны явцад хүний эрхийг хангах арга хэмжээний талаар прокурорын зөвшөөрөлд заахаар тусгасан. Дээрх хууль бус ажиллагаа нь Эрүүгийн хуулийн 13.6 дугаар зүйл /Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох/, 13.7 дугаар зүйл /Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх/ гэмт хэргийн шинжтэй эсэх талаар гомдол гаргаж шийдвэрлүүлэх шаардлагатай.

Хуульч, судлаач, Л.ГАЛБААТАР



Нээлттэй
Нийгэм
Форум



ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

ЮУ БОЛОВ?

2022 оны 2 дугаар сарын 18-ны өдөр ТЕГ-ын Олон нийттэй харилцах албаны ажилтан П.Өгөөмөр мэдээлэл өгөхдөө, Тагнуулын байгууллага Эрүүгийн хууль дахь “Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах” гэмт хэргийг илрүүлж, таслан зогсоож мөрдлөг явуулдаг. Монгол Улсын иргэн Ч.Мөнхбаярыг баривчилсан үйл явдалтай холбогдуулан прокурорын байгууллагаас зөвшөөрсөн хэмжээнд мэдээлэл хийе хэмээн тодотгоод “Иргэн Ч.Мөнхбаяр гадаадын тагнуулын байгууллагатай хамтран ажиллах, үүрэг даалгавар биелүүлсэн гэх нөхцөл байдал тогтоогдсон тул өчигдөр баривчлан саатуулсан. Мөн тэрбээр гадаадын тагнуулын байгууллагатай багагүй хугацаанд хамтран ажиллаж мөнгөн урамшуулал авч байсан бөгөөд түүнийг үйлдэл дээр нь баривчилсан. Иргэн Ч.Мөнхбаярын гэрээс иир хэмжээний мөнгө, валют илрүүлэн хураан аваад байна” гэлээ.



Эрүүгийн хуулийн 19.4 дүгээр зүйлд заасан “Монгол Улсын иргэн гадаад улсын тагнуулын албатай хамтран ажиллахаар тохиролцсон, хамтран ажилласан” гэдэг гэмт хэрэг нь дуу хоолой, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлах эрсдэлтэй зохицуулалт юм. Учир нь үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3-т зааснаар хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй хэдий ч 19 дүгээр зүйлийн 1-т зааснаас төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. Дээр дурдсан Эрүүгийн хууль дахь “гадаад улсын тагнуулын байгууллага”, “хамтран ажиллах”, “хамтран ажиллахаар тохиролцох” гэх ойлголтыг Эрүүгийн хууль болон Тагнуулын байгууллагын тухай хуульд тодорхойлоогүй бөгөөд зөвхөн тагнуулын мөрдөгч, прокурор, шүүхийн хүрээнд өөрсдөө тодорхойлж хэрэглэх үр дагавартай байна. Түүнчлэн тагнуулын байгууллагын үйл ажиллагаан дахь алдаа, дутагдлаас сэргийлэх механизм хангалттай бэхжээгүй үед үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хууль зүйн баталгаа бүрдээгүй гэж үзнэ.

Хуульч, судлаач, Л.ГАЛБААТАР



Нээлттэй
Нийгэм
Форум



ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ?



ЮУ БОЛОВ?

Нийслэлийн Засаг дарга асан, Монгол Улсын Баатар Э.Бат-Үүл 2021 оны арванхоёрдугаар сарын 20-ны өдөр хорих ангиас захидал бичсэн. Тэрээр захиандаа "АН-ын гишүүдэд шуналт олигархиудын эсрэг, ардчилал, эрх чөлөөний төлөө намаа нэгтгэхийг уриалсан" байдаг. Тэгвэл Э.Бат-Үүлийн хэвлэн нийтлэх эрхийг хаажээ.



ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

Үндсэн эрхийг зөвхөн хуулиар хязгаарлаж болно. Хууль нь зөвхөн "онцгой" нөхцөлийг хүлээн зөвшөөрдөг. Тэр нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээс урган гарна. Бусдаар шоронд хоригдож буй, ял шийтгэл эдэлж буй гэдэг үндэслэлээр хязгаарлах, хяхан боогдуулахыг зөвтгөдөггүй. [

Хэвлэн нийтлэх эрх чөлөөг ярихын тулд эхлээд мэдээллийн эрх чөлөөг анхааран үзэх хэрэгтэй. Мэдээллийг олж авах, эрж хайх, хүлээн авах, түгээх гэсэн 4 бүлэг эрх бий. Үүнээс түгээх эрхтэй нь хэвлэн нийтлэх эрх чөлөө илүүтэй холбогддог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хоригдлын хэвлэн нийтлэх эрхийг хязгаарлаагүй. Харин ч хүлээн зөвшөөрсөн. Тухайлбал, өөрийн зардлаар өдөр тутмын сонин, сэтгүүл захиалах, хорих анги дахь номын санг үнэ төлбөргүй ашиглах, хорих ял эдлэх нөхцөл, журам, эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах, захидлаар харилцах эрхүүдийг нэг бүрчлэн нэрлэн зааж баталгаажуулсан байна. Иймд мэдээлэл олж авч болж байгаа цагт эцсийн зорилго болох түгээх эрх буюу хэвлэн нийтлэх эрхээ эдлэх нь зөв юм.

Глоб Интернэшнл төвийн хуульч, Б.Пүрэвсүрэн



Нээлттэй
Нийгэм
Форум



ГЛОБ
ИНТЕРНЭШНЛ
ТӨВ


ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХИЙН ЗӨРЧИЛ МӨН ҮҮ?

ЮУ БОЛОВ?



MONGOLIAN NATIONAL BROADCASTER

МҮОНРТ-ээр 2021.03.03-ны өдөр 21:10 цагаас гарах байсан “BBC WORLD NEWS”, Дани улсын “THE WHY” байгууллагын хамтын бүтээл “Дэлхийн түүхүүд” цуврал баримтат киноны “Бид босогчид байсан” нэртэй дугаарыг МҮОНРТ-ийн Гүйцэтгэх удирдлага, удирдлагын багийн зүгээс цензурдаж цацахгүй гэсэн байна.



Хуульчийн тайлбар

Энэ нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1 дүгээр зүйл “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.” Түүнчлэн ОНРТХ-ийн 4.1 дүгээр зүйл “Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална” гэсэн зарчимтай нийцэхгүй байна. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн талаарх НҮБ-ын Хүний эрхийн хорооны 34 дүгээр тайлбарт “Гишүүн улсууд нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хараат бус байдлыг хангавал зохино” гэж заасан. Дэлхийн түүхүүд цуврал нь Монголын олон нийтийн медиа контент сан болон МҮОНРТ-ийн хамтарсан санаачлага бөгөөд олон нийтийн радио, телевизийн бодлого бус бөгөөд Үндэсний зөвлөл, Гүйцэтгэх удирдлагаас /цензур/ хяналт тавих, хориглох эрх зүйн зохицуулалт үйлчлэхгүй юм.

Глоб Интернэшнл төвийн хуульч, Б.Пүрэвсүрэн



ХУУЛЬЧИЙН ТАЙЛБАР

ЮУ БОЛОВ?

2022.03.03-ны өдөр цагдаагийн байгууллагын 102 дугаарын утсанд “Алтан тариа компани үйлдвэрийнхээ байрны гадна талд Украин улсын далбааг өлгөж хүмүүсийн дургүйцлийг хүргэж байна” гэх дуулга мэдээлэл иржээ. Энэ мэдээллийн дагуу Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн ажилчид очин далбааг буулгах шаардлага тавьсан байна.



“Энэ үйлдэл нь үзэл бодлоо илэрхийлэх илэрхийллийн хэлбэр бөгөөд түгээн дэлгэрүүлэх арга хэрэгсэл юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн талаарх НҮБ-ын Хүний эрхийн хорооны 34 дүгээр тайлбарт “илэрхийллийн бүхий л хэлбэр, түүнийг дэлгэрүүлэх арга хэрэгслийг хамгаална. Эдгээрт яриа, бичиг, дохионы хэл, дүрс, урлагийн бүтээл гэх мэт аман бус хэлбэр багтана. Ном, сонин, товхимол, зурагт хуудас, баннер, хувцас болон хуулийн дагуу гомдол гаргах нь илэрхийллийн арга хэрэгсэлд орно. Эдгээрт дуу, дүрс, электрон интернэтэд суурилсан илэрхийлэл багтана” гэж заасан. Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө хэмээх хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахааар шүүхэд гомдол гаргах” нь Монгол улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөнд хамаарна. Иргэн төрийн үйлчилгээ, хүнд суртал, төрийн ажилтны хайнга байдлаас болж хохирсон бол гомдол гаргаж, хохирлоо нэхэмжлэх эрхтэй. Өөрийнх нь эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэж үзсэн иргэн Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисст хандан гомдол гаргах эрхтэй.

**ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВИЙН
ХУУЛЬЧ, Б.ПҮРЭВСҮРЭН**

Хавсралт 2. Ковид 19 буюу коронавируст цар тахлын үе дэх сэтгүүлчдийн аюулгүй байдлын судалгааны дүн

Глоб Интернэшнл төв нь Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр 2020 оны 11 дүгээр сарын 20-оос 2022 оны 3 сарын 31-ний хугацаанд хэрэгжүүлсэн “Ковид-19 ба Иргэний улс төрийн эрхийн зөрчлийн мониторинг” төслийн хүрээнд энэхүү судалгааг авсан болно.

Судалгааны зорилго:

Ковид 19 буюу коронавирус цар тахлын эсрэг хариу арга хэмжээ буюу бүх нийтийн бэлэн байдлын зэрэг болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг зарласан хугацаанд сэтгүүлчдэд тулгарсан мэргэжлийн эрхийн зөрчлүүдийг илрүүлэх, бүртгэх, нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах зорилгоор судалгаа хийв.

Судалгааны арга зүй:

Тус судалгаанд Улаанбаатар хотын болон орон нутгийн телевиз, сонин, сэтгүүл, радио, фм, цахим хуудасны нийт 237 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан хамрагдав.

Судалгааны мэдээллийг биечлэн болон цахим хэлбэрээр цуглуулав. Судалгаанд нийт 237 хүн хамрагдсанаас 160 судалгааг биечлэн уулзах замаар, 77 судалгааг цахим хэлбэрээр цуглуулав. Нийт 237 хүн судалгаанд хамрагдсан боловч 4 оролцогч судалгааны асуултад дутуу хариулсан, үр дүнд нэгтгэхэд чанар хангаагүй тул 233 судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нэг. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


Тус судалгаанд Улаанбаатар хотын болон орон нутгийн телевиз, сонин, сэтгүүл, радио, фм, цахим хуудасны нийт 233 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан хамрагдав. Судалгаанд оролцогчдын 76 хувь нь Улаанбаатар хотоос, 14 хувь нь орон нутагт ажилладаг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан байв. Хүйсээр нь ангилбал 70 хувь нь эмэгтэй, 30 хувь нь эрэгтэй хүн байв. Хэвлэл мэдээллийн аль салбарт ажиллаж буйгаар нь ангилан үзвэл телевизэд ажилладаг хүмүүс хамгийн их буюу 38 хувийг эзэлжээ. Харин 21 хувь нь цахим хуудаст, 18 хувь нь сонинд, 15 хувь нь радио, фм-д, үлдсэн 3 хувь нь сэтгүүлд ажилладаг байна.

Хоёр. Сэтгүүлчдийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс

2.1. Сэтгүүл зүйн салбараас олдог орлогын хэмжээ

Хэвлэл мэдээллийн салбарт ажилладаг хүмүүсийн дийлэнх нь буюу 85 хувь нийт орлогынхоо 50-иас дээш хувийг хэвлэл мэдээллийн салбарт ажилласан цалин урамшууллаар олдог гэж хариулжээ. Тухайлбал 61-ээс дээш хувь нь нийт орлогынхоо 71-100 хувийг тус салбарт гүйцэтгэсэн цалин урамшууллаараа олдог гэсэн бол 24 хувь нь 51-70 хувийг олдог гэжээ. Харин 31-50 хувь гэж 9 хувь нь хариулсан бол 30-аас доош гэж үлдсэн 6 хувь нь хариулав.


Хэвлэл мэдээллийн салбараас олдог орлогын эзлэх хувь



2.2. Цалин урамшуулалдаа сэтгэл ханамжтай эсэх


Цалин урамшуулал нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын амьдралын баталгаа болохын хувьд тус салбараас олсон орлогодоо хэр зэрэг сэтгэл хангалуун байгааг нь тодруулахад маш хангалуун буюу хангалуун гэж $\frac{1}{4}$ орчим хувь нь хариулсан бол хангалуун биш буюу сэтгэл дундуур гэж 35 хувь нь хариулжээ. Харин сэтгэл ханамж дунд зэрэг гэж 39 хувь нь хангалуун биш гэж 27 хувь, огт сэтгэл ханамжгүй гэж 8 хувь нь дүгнэсэн юм.

Цалин урамшуулалдаа сэтгэл ханамжтай эсэх



Цалин урамшуулалдаа сэтгэл хангалуун гэж хариулсан хүмүүсийг ямар төрлийн мэдээлэл бэлтгэдэг эсэхийг сэдвээр нь задлан харвал урлаг соёл 12 хувь, улс төр 10 хувь, эрүүл мэнд, эдийн засгийн чиглэлээр мэдээлэл бэлтгэдэг сэтгүүлч адил тэнцүү 9 хувийг тус тус эзэлж байгаа нь бусдаасаа өндөр байна.


Цалин, урамшуулалдаа сэтгэл хангалуун



2.3. Ямар сэдвээр мэдээлэл бэлтгэдэг вэ?

Монголын хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй сэтгүүлч болон бусад мэргэжлийн хүмүүс нь зөвхөн нэг сэдвээр дагнан мэдээлэл бэлтгэх нь ховор тул нийгмийн ямар асуудлаар голчлон мэдээлэл бэлтгэдэг эсэхийг нь тодруулсан юм. Судалгаанд хамрагдсан хүмүүс давхардсан тоогоор талаас илүү буюу 55% нь урлаг, соёлын, 43 хувь нь улс төр, 42 хувь нь эрүүл мэнд, 39 хувь нь хүний эрх,

36% нь эдийн засгийн чиглэлээр мэдээ, нийтлэл, сурвалжлага, нэвтрүүлэг бэлтгэн хүргэдэг байна.



2.4. Ажлын техник, тоног төхөөрөмж

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг хүмүүсийн аюулгүй байдлын хувьд ажлын багаж хэрэгсэл нь буюу техник тоног төхөөрөмж маш чухал байр суурь эзэлдэг. Судалгаанд хамрагдагсдын ажлын гол хэрэгсэл суурин компьютер гэж $\frac{1}{4}$ -ээс илүү нь хариулжээ. Хоёрдугаарт хэрэглээгээрээ гар утас нэрлэгдсэн нь 59 хувийг эзэлж байна. Түүнчлэн зөөврийн компьютер 33 хувь, диктафон буюу дуу хураагч, зургийн аппарат адил тэнцүү 28 хувийг эзэлж байна. Харин бусад тоног төхөөрөмж гэж 7 хувь нь хариулжээ.


Ажлын төхөөрөмж



2.5. Ашигладаг цахим шуудан

Сэтгүүлчдийн аюулгүй байдалд шууд хамааралтай мэдээлэл дамжуулах, хүлээн авах суваг бол цахим шуудан юм. Судалгаанд хамрагдсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудаас ямар төрлийн цахим шуудан ашигладаг эсэхийг нь тодруулахад дийлэнх буюу 87 хувь нь @gmail, 24 хувь нь @yahoo, 15 хувь нь өөрийн байгууллагын домэйн хаяг дээрх имэйл, 2 хувь нь @hotmail гэж хариулсан байна. Үлдсэн 3 хувь нь өөр, бусад төрлийн имэйл хаяг ашигладаг гэжээ. Эндээс дүгнэхэд сэтгүүлчид "хамгаалагдсан" цахим шуудан ашигладаггүй болох нь харагдаж байна.


Ямар имэйл ашигладаг вэ?



2.6. Ашигладаг нийгмийн сүлжээ

Мэдээлэл солилцох, хүлээж авах хамгийн хүртээмжтэй хэрэгсэл болохын хувьд хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын нийгмийн сүлжээ ашиглалтын байдалд тандалт хийхэд нийт судалгаанд хамрагдагсдын 99 хувь нь facebook ашигладаг гэсэн бол youtube суваг ашигладаг гэж 67 хувь нь хариулсан юм. Түүнчлэн google+ ашигладаг 55 хувь, instagram ашигладаг 54 хувь, twitter ашигладаг хэмээн 42 хувь нь хариулсан юм. Харин ажил мэргэжлийн сүлжээ болох linkedin-ыг ердөө 12 хувь нь ашигладаг байна.


Нийгмийн сүлжээний хэрэгэлээ



2.7 Хамгийн чухал аюулгүй байдлын асуудал

Хэвлэл мэдээллийн салбарт ажилладаг хүмүүсийн хувьд хамгийн чухал аюулгүй байдлын асуудал юу вэ? гэсэн асуултад нэгдүгээрт хувийн аюулгүй байдал чухал гэж нийт оролцогчдын 51 хувь нь хариулсан бол эх сурвалжийн аюулгүй байдлын асуудал чухал гэж 45 хувь, мэдээллийн аюулгүй байдал чухал гэж 44 хувь нь хариулсан байна. Харин гэр бүлийн аюулгүй байдал чухал гэж 18 хувь нь, хамт ажиллагсдын аюулгүй байдал гэж 12 хувь нь дүгнэжээ. Түүнчлэн дээрх асуудлуудын аль нь хамгийн чухал эсэхийг хариулж мэдэхгүй гэж судалгаанд оролцсон хүмүүсийн 7 хувь нь хариулсан байна.

Хамгийн чухал аюулгүй байлын асуудал




2.8. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудад тулгардаг асуудлууд

Сэтгүүлч хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудад тулгардаг асуудлын нэгдүгээрт мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалздаг явдал гэж хариулжээ. Энэ нь судалгаанд оролцогчдын 57 хувийг эзэлсэн нь анхаарал татахуйц байна. Хоёрдугаарт шүүх, цагдаа, прокуророос дуудах гэж 20 хувь нь хариулсан юм. Харин асуудлын гуравдугаарт имэйл, болон утасны мессэжээр заналхийлэх асуудал бүртгэгдэв. Цаашлаад биечлэн заналхийлэх, мэдээлэл хулгайлах, хувийн онлайн орон зайд халдаж мөрдлөг хийх, хакердах гэсэн асуудлуудыг нэрлэсэн байна.

№	Асуудлууд	Эзлэх хувь
1	Мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзах	57%
2	Шүүх, цагдаа, прокуророос дуудах	20%
3	Имэйл болон утсаар заналхийлэх	18%

4	Биечлэн заналхийлэх	16%
5	Мэдээлэл хулгайлах	15%
6	Хувийн онлайн орон зайд халдаж, мөрдлөг хийх, хакердах	12%
7	Цахим шууданд халдах	9%
8	Ажлын онлайн орон зайд халдаж, мөрдлөг хийх, хакердах	8%
9	Техник, технологид халдах /вирус тараах/	6%
10	Утасны яриа чагнах, бичлэг хийх	5%
11	Биетээр халдах	5%
12	Нэгжлэг, үзлэг хийх	4%
13	Бусад асуудлууд	4%
14	Хууль бусаар баривчлах	3%
15	Найз нөхөд, гэр бүл, хамтран ажиллагсдыг заналхийлэх	1%
НИЙТ		100%

Хамгийн их тулгардаг асуудал



2.9. Эрх зөрчигч субъектууд

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын эрх ашгийг ямар субъект хамгийн их зөрчдөг вэ гэсэн асуултад эрх мэдэл бүхий албан тушаалтнууд гэж судалгаанд оролцогчдын 61 хувь нь хариулсан юм. Үүний дараа хууль сахиулагчид гэж 18 хувь нь, ажил олгогч гэж 17 хувь нь, хэвлэл мэдээллийн салбарын хүмүүс хэмээн 11 хувь нь хариулав. Харин хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч, иргэд, олон нийт гэж адил тэнцүү 8 хувь нь хариулсан бол редакц эрх зөрчдөг гэж 5 хувь нь тодорхойлжээ.


Хэн эрх зөрчдөг вэ?



2.10 Эрх зөрчигдсөн байдал

Ажил үүргээ гүйцэтгэх явцад эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж судалгаанд оролцогчдын 47 хувь хариулсан бол эрх зөрчигдсөн эсэхээ хариулж мэдэхгүй хэмээн 17 хувь нь хариулсан нь ноцтой үзэгдэл юм. Үлдсэн 36 хувь нь эрх, эрх чөлөө зөрчигдөөгүй гэж хариулав.


Таны эрх зөрчигдсөн үү?



Эрх нь зөрчигдсөн хүмүүсийн 63 хувь нь Улаанбаатар хотын харьяалалтай байсан бол үлдсэн 37 хувь нь хөдөө, орон нутгийн сэтгүүлчид ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнууд байна. Хүйсийн хувьд ангилан үзвэл дийлэнх нь буюу 69 хувь нь эмэгтэйчүүд, үлдсэн 31 хувь нь эрэгтэйчүүд байна.

Түүнчлэн ямар сэдвээр мэдээлэл бэлтгэдэг сэтгүүлчид хамгийн их эрх нь зөрчигдөж буйг судлахад улс төр, урлаг соёл, хүний эрхийн чиглэлээр мэдээлэл бэлтгэдэг сэтгүүлчид хамгийн их эрх нь зөрчигддөг болох нь судалгааны дүнгээс ажиглагдлаа.

Эрх нь зөрчигдсөн сэтгүүлчид ямар сэдвээр мэдээлэл бэлтгэдэг вэ?



2.11 Таны ямар эрх зөрчигдсөн бэ?

Эрх нь зөрчигдсөн гэж хариулсан хүмүүсээс яг ямар эрх нь зөрчигдсөн эсэхийг тодруулбал давхардсан тоогоор мэдээлэл авах эрх зөрчигдсөн гэж 50 хувь нь хариулав. Мөн түүнчлэн хэвлэн нийтлэх эрх зөрчигдсөн гэж 41 хувь, үзэл бодлоо илэрхийлэх эрх зөрчигдсөн гэж 36 хувь, эх сурвалжаа хамгаалах эрх зөрчигдсөн гэж 27, ажлын техник хэрэгсэлд халдсан, ажиллах орчин нөхцөл таагүй гэж адил тэнцүү 17 хувь, бие махбодод халдсан гэж 8 хувь, ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн хэмээн 6 хувь нь тус тус хариулжээ.


Таны ямар эрх зөрчигдсөн бэ?



2.12. Таны эрх хэзээ зөрчигдсөн бэ?

Ковид 19 ба коронавируст цар тахлын эсрэг хариу арга хэмжээ буюу өндөржүүлсэн бэлэн байдлын үе болон бэлэн байдлын зэргийн үеийг хамруулан авсан энэхүү судалгаанд эрх нь зөрчигдсөн гэж хариулсан хүмүүсийн зөрчлийг хугацаагаар нь ангилан харуулбал 2020 хамгийн их зөрчил гарсан нь 49 хувийг эзэлж байна. Харин 2021 онд мэргэжлийн эрх зөрчигдсөн гэж судалгаанд оролцогчдын 37 хувь нь хариулсан бол 2022 онд эрх зөрчигдсөн гэж 14 хувь нь хариулав.


Зөрчил гарсан хугацаа /хувиар/




2.13 Сэтгэл зүйн дарамт, сэтгэл санааны хохирол амсдаг эсэх

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын бараг 2 хүн тутмын нэг нь сэтгэл зүйн дарамтад ордог байна. Учир нь дээрх асуултад судалгаанд оролцогчдын тал орчим нь буюу 48 хувь нь “тийм” гэж хариулсан юм. Харин сэтгэл санааны дарамтад хэр давтамжтай ордог вэ гэсэн асуултад байнга болон ихэвчлэн гэж 13 хувь нь, заримдаа гэж 25 хувь нь, хааяа гэж 44 хувь нь, огт үгүй гэж 18 хувь нь хариулав.

Та эрхэлж буй ажил үүрэгтэйгээ холбоотойгоор сэтгэл санааны дарамт, хохирол амсдаг уу?



Сэтгэл санааны дарамтад хэр их ордог вэ?



2.14. Ажлын техник хэрэгсэл, эд хогшилд халдсан эсэх

Судалгаанд оролцогчдын 9 хувь нь ажлын техник хэрэгсэл, эд хогшилд 1-2 удаа халдсан гэж хариулав.



2.15. Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад тулгарч буй дээрх асуудлуудын эсрэг авч хэрэгжүүлэх хамгийн чухал арга хэмжээ бол эрх зүйн орчныг сайжруулах гэж нийт оролцогчдын 64 хувь нь хариулав. Мөн цалин урамшуулал нэмэх асуудал чухал гэж хоёр хүн тутмын нэг нь хариулсан байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчдэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж нийт оролцогчдын 29 хувь нь хариулсан бол сургалт явуулах шаардлагатай гэж 25 хувь нь, улс төрийн орчныг сайжруулах нь чухал гэж 16 хувь нь үзжээ. Харин сэтгүүлчдийн аюулгүй байдлыг сайжруулахад нөлөөлж болохуйц чухал алхам бол эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдийн хууль ёсны эрхийг хамгаалах, эрхэд халдсан үйлдлийн шийтгэлийг чангатгах явдал гэж судалгаанд хамрагдсан хүмүүсийн 14 хувь нь хариулав.



2.16. Сэтгүүлчдэд тулгарсан тохиолдлууд:

- Ярилцлага нийтэлсний төлөө редакцын утас уруу Орхон аймгийн Засаг дарга залгаж ална шүү мэдээгээ устга гэж ярьсан. Мөн хуучин ажиллаж байсан сайтын эрхлэгчийг ярилцлага авсны төлөө ТЕГ-ын мөрдөн байцаагч зөвшөөрөлгүйгээр редакцад нэвтэрч хүчээр байцаалтад авч явах гэж оролдсон.
- Гудамжинд явж байхдаа сэтгүүлч, зураглаачийг цохиж, зодох тохиолдол их гардаг.
- Сэтгүүлч, сэтгүүлчээ дарамтлах тохиолдол их байдаг.
- Улс төрийн асуудлаар шүүмжлэлт мэдээлэл бэлтгэсэн сэтгүүлчийг нийгмийн сүлжээгээр доромжилж, заналхийлэх тохиолдол их байдаг.
- Манай эрхлэгч танилтайгаа утсаар ярихдаа өөр нэгэн хүнийг шүүмжилсэн өнгө аястай ярилцаж байхад нь хажууд нь байсан цагдаагийн алба хаагч нууцаар бичлэг хийж, түүнийгээ нөгөөх шүүмжлүүлсэн хүнд нь сонсгож, таагүй харилцаа үүсгэсэн тохиолдол гарсан.
- Бэлгийн дарамтад өртсөн. Энэ талаараа Хан-Уул дүүргийн цагдаагийн хэлтэст өргөдөл өгсөн.
- Эх сурвалжийн ажлын байранд нэвтэрч, танхайрсан тохиолдол гарсан.
- Мэдээлэл авахаар очсон сэтгүүлчийг элдэв үгээр доромжилж, мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдол гарсан.

2.17. Сэтгүүлчдийн аюулгүй байдал, эрхийн асуудлаар дээрх асуултад дурдагдаагүй нэмж хэлэх санал байна уу?

- Хэвлэл мэдээллийн байгууллагууд мэргэжлийн сэтгэл зүйчийг гэрээгээр ажиллуулдаг байх шаардлагатай.
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тухайн орон нутгийнхаа засаг захиргаа, улс төрчидтэй гэрээлэн ажилладаг тул нийтийн эрх ашгийн төлөөх шүүмжлэлт мэдээллүүд нийтлэх нь хязгаарлагдмал болсныг анхаарч үзэх

ДҮГНЭЛТ

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл болсон 233 хүн хамрагдсан тус судалгаанд оролцогчдын 76 хувь нь Улаанбаатар хотоос, 24 хувь нь хөдөө, орон нутагт ажилладаг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан байв. Хүйсээр нь ангилбал 70 хувь нь эмэгтэй, 30 хувь нь эрэгтэй хүн байна. Хэвлэл мэдээллийн салбарт ажилладаг хүмүүсийн хувьд хамгийн чухал аюулгүй байдлын нэгдүгээрт хувийн аюулгүй байдал чухал, хоёрдугаарт эх сурвалжийн аюулгүй байдал, гуравдугаарт мэдээллийн аюулгүй байдал буюу өгөгдөл, дататай холбоотой аюулгүй байдал чухал гэж хариулсан байна. Энэ нь цахим дайралт газар авч, хууль бусаар мөрдөн мөшгөх, технологи ашиглан тагнах чагнах асуудалтай нүүр тулж буйн илрэл юм.

Сэтгүүлчдийн эрх ашгийг хэн зөрчөөд байгаа талаар 233 хүний 184 нь эрх мэдэл бүхий албан тушаалтан, хууль сахиулагчид гэж хариулсан байна. Тулгамдаад буй аюулгүй байдлыг хангахын тулд цаашид авах арга хэмжээний эхэнд эрх зүйн орчныг сайжруулъя гэж нийт судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 64 хувь нь үзжээ.

Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй хүмүүсийн цалин хөлс маш бага байгаа талаар судалгаа хийгдсэн байдаг. Гэтэл эдийн засгийн баталгаа болох цалин хөлсөө нэмүүлэх асуудал чухал гэж 51 хувь нь хариулав. Асуудлын гуравдугаарт хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн талаарх олон нийтийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж 38 хувьтай хариулсан байна. Энэ нь дэлхий дахинд цар тахалтай холбоотойгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийн индекс буурч байгаагийн тод илрэл юм.

Ил тод байдал нийтийн сайн сайхны төлөө байх тухай ойлголтыг уландаа гишгэж байна. Жирийн иргэн бүү хэл сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага нь төрийн байгууллагаас мэдээлэл олж авна гэдэг нэн хүндрэлтэй асуудал байсаар ирсэн. Учир нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарт тулгардаг асуудлын хамгийн эхэнд “мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалздаг” гэсэн асуудал нэрлэгдсээр байгаа юм. Иймд 2022.05.01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг бүх түвшиндээ анхаарч ажиллах хэрэгтэй байна.



Хавсралт 3. Монгол Улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүрэн дүүрэн баталгаажуулахад дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаарх санал

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зохисгүйгээр хязгаарлаж буй хууль тогтоомжийг өөрчлөх зарим санал		Өөрчлөх хувилбар
№	Монгол Улсын хууль тогтоомж	Өөрчлөх нөхцөл шаардлага
1	Зөрчлийн тухай хууль	Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйл "Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих" зөрчил 2020 онд 1790 гарснаас хялбаршуулсан журмаар 667 зөрчлийг шалган шийдвэрлэж, 1123 хэрэг нээн шалгаж, 1480 хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан тухай УЕПГ-ын 2021.06.18-ны өдрийн 4/3650 албан бичиг дурдсан байна. Үүнээс 190 зөрчлийн хэрэг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгджээ.
2	Эрүүгийн хууль	Улсын Их Хурлын хувьд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль дахь "худал мэдээлэл", "илт худал мэдээлэл" гэх зохицуулалт "Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй", "Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй" гэсэн зарчимтай шууд харшилж байгааг хүлээн зөвшөөрч: Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1-т заасан "Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээх", зөрчлийг хасах; Нөгөө талаас, "Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн 7.1.11 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах нь Засгийн газрын үүрэг байхаар хуульчилсан. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1-т заасан "Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараах" гэмт хэргийг хасах эсхүл өөрчлөн найруулах

		нэг хэргийг хэрэгсэхгүй болгож, найман хэрэгт ялах дүгнэлт үйлдсэн байна. Одоо ажиллагаанд 128 хэрэг шалгагдаж байгаа тухай УЕПГ-ын 2021.06.18-ны өдрийн 4/3650 албан бичиг дурдсан байна. 2002 оны Эрүүгийн хуульд байсан "гүтгэх" гэмт хэргээс өргөн хүрээ, агуулгатай байгаа нь асуудал дагуулж байна. Тухайлбал, гутаасан болон гутаах зорилго агуулгатай эсэхийг тодорхойлоогүй орхигдуулснаар нэр томьёо, ойлголтын зөрүүтэй байдал үүсгэсэн. Энэ гэмт хэргийн улмаас улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн байгууллага гомдол гаргах эрхтэй байхаар зохицуулсан нь хуулийг урвуугаар ашиглаж, нийгэмд шударга шүүмжлэл өрнүүлэх асуудлыг нухчин дарах гэсэн оролдлого болж байна. Практик дээр Иргэний хуулиар зохицуулж буй нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан нэхэмжлэлтэй хэрэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу давхар шалгагдах боломжийг хязгаарлаагүйгээс эрх зүйн давхардал үүсгэж байна. 2020 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах талаар Монгол Улсад "Гүтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх арга хэмжээ авах зэрэг замаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэний нийгмийн идэвхтнүүд аливаа шийтгэл хүлээнэ гэх айдасгүйгээр үйл ажиллагаагаа олон улсын хэм хэмжээний дагуу чөлөөтэй явуулах нөхцөлийг хангах" тухай зөвлөмж өгсөн.	Хэвлэл мэдээллийн зохицуулалт нь хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлын зарчмыг хангахад чиглэх бөгөөд үүнд хэвлэл мэдээлэл нь төрийн шууд болон шууд бус хяналтаас ангид байх; редакцын хараат бус байдал – хэвлэл мэдээллийн ажилтнууд, редакторууд юуг нийтлэх, ямар агуулгыг нийтлэх
3	Өөрчлөн найруулах, нэмж тусгах шаардлагатай зохицуулалтууд		Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль ба Төрийн болон албаны нууцын тухай хуульд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан "мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлахад баримтлах шалгуур" буюу 1/ тухайн мэдээлэл нь хуульд заасан хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой

	талаар шийдвэр гаргах боломжтой байхыг ойлгоно. Иймд, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэгэнт заасан агуулгын хязгаарлалтыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, бусад хуульд дахин заах шаардлагагүй бөгөөд хэвлэл мэдээллийн эрх чөлөөний бие даасан байдлыг алдагдуулах, ойлгомжгүй байдлыг бий болгох, улс төрийн зорилгоор хэрэглэгдэх үр дагавартай тул дараах хууль тогтоомжийн зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай байна. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Хүүхдийн эрхийн тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх, Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай зэрэг олон хуульд агуулгын хязгаарлалтыг тогтоосон. Эдгээр хязгаарлалт нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хийгдсэнийг бид хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч нэр томъёоны хувьд хэт ерөнхий, нарийн тодорхойлолт байхгүй, хамрах хүрээг тогтоогоогүй байдал нь хязгаарлалтыг хэтрүүлэх нөхцөл үүсгэж болзошгүй. Үүнээс гадна, чөлөөт шүүмжлэл өрнүүлсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагаанд хэтийдсэн хязгаарлалт тогтоож ч болохоор эрсдэл дагуулж байна.
байх, 2/ тухайн мэдээллийг ил болгох, задруулах нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд ноцтой хохирол учрахыг хохирлын үнэлгээгээр заавал тогтоосон байх, 3/ тэрхүү учрах ноцтой хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлоос илүү чухал байх гурван нөхцөлийг нэгэн зэрэг хангасан тохиолдолд мэдээллийг нийтэд мэдээлэхгүй байх, төрийн болон албаны нууцад хамааруулах талаар нэмж тусгаж, дагаж мөрдүүлэх.	Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2020 оны А/200, А/169 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Цар тэхлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам"-д заасан эрх бүхий байгууллагын дүгнэлт, саналд хөндлөнгийн этгээд буюу шинжээчийн дүгнэлт гаргуулж байх талаар өөрчлөлт оруулах. Энэ хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрх журмуудын дагуу шийдвэрлэж буй гомдлын агуулга, шийдвэрийн талаар тухай бүр цахим хуудсаараа дамжуулан ил тод мэдээлж байх. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг Засгийн газрын тогтоолоор²⁴ биш, зөвхөн хуулиар тогтоох тухай холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, ил болгохтой холбоотой асуудлыг шийдэхэд иргэний нийгэм, тэр дундаа хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийн оролцоог хангах талаар холбогдох хууль, журамд тусгах. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын мөрдөж буй нууцын журам болон жагсаалтыг олон нийтэд ил тод болгох. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бие даасан байгууллага, нэгж, түүний эрх хэмжээг тус хуульд нэмж тусгах.

²⁴ Мөнөөдөр Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмыг Засгийн газрын 246 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан.

		Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлд заасан “Төрийн нууцыг хууль бусаар олж авах” гэмт хэргийн үйлдсэн этгээд нь төрийн нууцыг итгэмжлэн хариуцсан этгээд, эсхүл албан тушаал, албан үүргийн хувьд мэдсэн этгээд байхаар өөрчлөн найруулах, эсхүл хүчингүй болгох. Эрүүгийн хуулийн 14.2 дугаар зүйлд заасан “Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах”, 14.3 дугаар зүйлд заасан “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэрэгт оногдуулах ялыг хүндрүүлэх. Мөн энэ төрлийн гэмт хэргийг шалган шийдвэрлэх албан хаагчдыг бэлтгэх буюу харьяалал тогтоох. Олон нийтийн эрх ашгийн төлөө асуудал дэвшүүлсэн нийтлэл бичсэн, бүтээл туурвисан, сэтгүүл зүйн бусад үйл ажиллагаа явуулсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны эсрэг хуулийн маргааныг тусгайлан журмаар буюу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангахад чиглэсэн журмын дагуу шийдвэрлэх зохицуулалтыг процессын хуулиудад тусгах. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд “Шүгэл үлээгч нь өөрийн хувийн мэдээллийг ил болгохгүйгээр өөрийн өмнөөс хуульчаар, эсхүл сэтгүүлчээр дамжуулан шүгэл үлээж болно. Энэ тохиолдолд шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг хуульчийн, эсхүл сэтгүүлчийн мэдээллээр орлуулна. Сэтгүүлчээс шүгэл үлээгчийн үйл ажиллагаатай нь холбогдуулан гэрчээр болон бусад байдлаар байцаах, нөхцөл байдлыг тодруулах зорилгоор мэдүүлэг, тайлбар авах, шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг шаардахыг хориглоно.” гэж тусгах. Харилцаа холбооны тухай хууль дахь Ерөнхий сайд тус хорооны гишүүдийг томилдог заалтыг өөрчилж УИХ томилдог болох.
4	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэх болон нэвтрүүлэхэд нь хууль тогтоомжоор хязгаарлалт тавьсан. ИБУТЭОУП-ын 20 дугаар зүйлээр дайныг	



Хасах шаардлагатай зохицуулалтууд	сурталчлах, алагчлан дайсагналцах, хүчирхийллийг өдөөн турхирах, арьс өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зэргийг хориглохоор заасан. Гэхдээ үүнийг хэт өргөн эсхүл хэт бүрхэг тодорхойлдог учраас буруугаар хэрэглэх нөхцөл бүрдүүлэх эрсдэлтэй. Иймээс, Монгол Улсын хууль, тогтоомжид төрийн мэдээллийг заавал дамжуулах үүргийг онгодуулсан хуулиудыг нягтлан зайлшгүйгээс бусад шаардлагагүй зохицуулалтыг хүчингүй болгох, хасах шаардлагатай байна.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйл /Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг/-ийг хасах. Гамшгаас хамгаалах тухай хуулийн "10.4.13.олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх," гэснийг хасах. "Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн 9.13-т "Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана" гэснийг хасах. "Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн 14.1-т "Хэвлэл мэдээллийн байгууллага цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Улсын онцгой комисс болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн сэрэмжлүүлэг, мэдээллийг олон нийтэд үнэ төлбөргүй, саадгүйгээр мэдээлнэ", 14.2-т "Цар тахлын талаарх цаг үеийн болон түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой үнэн, бодит мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авч олон нийтэд хүргэнэ" гэснийг хасах. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.2.2 болон 9.2.3-р зүйлд "хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл ба төрийн хяналт шалгалтын явцад болон шийдвэр хүчин төгөлдөр болох
-----------------------------------	--	---

		хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаахыг оруулсан нь Иргэн, Эрүүгийн хуулиар зохицуулдаг харилцаа бөгөөд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг үндэслэлгүйгээр хязгаарлах, дарамт шахалт учруулах боломжийг бүрдүүлэх эрсдэлтэй.	хүртэлх хугацаанд цуглуулсан мэдээлэл" хязгаарлалттай байна гэснийг хасах Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.3-т "контентийн үйлчилгээ эрхлэх" гэснийг хасах. Цагдаагийн албаны тухай хуулийн 59.1.2-т "Шуурхай мэдээлэл нийтэд түгээх шаардлага гарсан тохиолдолд өмчийн харьяалал харгалзахгүйгээр хэвлэл, мэдээлэл, холбооны хэрэгсэл ашиглах" гэснийг хасах. Хүний эрх хамгаалагчийн тухай хуулийн 8.2-т "хүний эрх, эрх чөлөө, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах"-ыг хориглохоор заасныг хасах.
--	--	--	--

